ХҮҮХЭД БОЛОН НАСАНД ХҮРЭГЧДЭД
ЗОРИУЛСАН ИСЛАМ ШАШИНЫ НОМ

АБДЕСТ-ГУСУЛ БОЛОН МӨРГӨЛӨӨ СУРЧ БАЙНА



Асим Уясал

ERKAM PUBLICATIONS

بسم الله الرحمن الرحيم

Истанбул - 1438 / 2017

© Erkam Publications - İstanbul: 1438/2017

Бүх эрх нь хамгаалагдсан. Уг ном нь хэвлэсэн компанийн өмч бөгөөд номын аль ч хэсгийг хэвлэгчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, олшруулан нийтлүүлэхийг хориглоно.

Номын Түрк хэлний эхний жинхэнэ хэр :	Abdest, Gusül ve Namaz Öğreniyorum
Зохиолч нь :	Асим Уясал
Орчуулсан нь :	Цэвээн Сайнжаргал
Найруулсан нь :	Бээжээ Баттогтох
Хавтасны дизайн :	Мустафа Каяан
График :	Мустафа Каяан
Хэвлэсэн газар :	Erkam Publications
ISBN :	978-605-302-353-1
Хэвлэсэн газар :	İkitelli Organize Sanayi Bölgesi Mah. Atatürk Bulvarı, Haseyad 1. Kısım No: 60/3-C Başakşehir, İstanbul, Türkiye
Утас :	(90-212) 671-0700 pbx
Факс :	(90-212) 671-0748
Э-мэйл :	info@islamicpublishing.org
Тор нь :	www.islamicpublishing.org
Language :	Mongolian

ERKAM PUBLICATIONS

ХҮҮХЭД БОЛОН НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛСАН
ИСЛАМ ШАШИНЫ НОМ

Абдэст-Гусул болон Мөргөлөө Сурч Байна

Асим Уясал

Истанбул - 2017

بسم الله الرحمن الرحيم

“Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм.”

“Энэрэл Нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлээ.”

БИСМИЛЛА

Анх хэлсэн үг минь Аллах.
Бие сэтгэл минь итгэл үнэмшлээр дүүрэн.
Өглөө бүр сэрээд,
Бисмиллах гэж би хэлдэг.
Идэж уух бүртээ,
Номоо дэлгэхдээ,
Би Рабб Эзэн рүүгээ чиглэдэг.
Зүрхэнд минь хүч чадал нэмэгддэг.
Тиймээс би хэлнээсээ салгадаггүй,
Аллах гараас минь атгадаг.

М. Асим КӨКСАЛ

АСУУЛТ ХАРИУЛТ БҮХИЙ ШАШИНЫ АНХНЫ МЭДЭГДЭХҮҮНҮҮД

Рабб Эзэн чинь хэн бэ? Цор ганц Аллах.

Чамайг хэн бүтээсэн бэ? Аллах Эзэн бүтээсэн.

Чи хэний боол/албат вэ? Би бол Аллахын боол.

Бид хаанаас ирээд, хаашаа буцах вэ? Бид Аллахаас ирээд, буцаад Аллахад очих болно.

Бид юуны төлөө бүтээгдсэн бэ? Аллахад албат байж ибадэт үйлдэхийн төлөө бүтээгдсэн.

Боол/албатын үүрэг нь юу вэ? Аллахад ибадэт үйлдэж, Түүний Элчид дагаар орж, Аллахын шашин болох Исламыг газар дэлхийд тарааж мөн өөрийн биеэр амьдралынхаа туршид мөрдөхийг хэлнэ.

Бид хэзээнээс эхлээд мусульман бэ? (Коолу Бэлаа)-гаас эхлүүлээд мусульман.

(Коолу Бэлаа) гэж юу гэсэн үг вэ? Агуу Аллах дэлхий ертөнцийг бүтээхээсээ өмнө, өнгөрсөн болон ирээдүйн бүх хүмүүсийн сүнсийг бүтээсэн гэдэг, тийнхүү бүгдийг нь өмнөө дуудан:

- “Элэсту бироббикүм” (Би та нарын Эзэн биш гэж үү?) хэмээн асуухад, Сүнснүүд хариуд нь:

- (Тиймээ, Та бол бидний Эзэн) хэмээж, “Зөвхөн танд албат байж мөн зөвхөн танаас л тусламж хүсэх болно” хэмээн амласан гэдэг.

Энэхүү ярилцсан үеийг (Коолу Бэлаа) хэмээн нэрлэж байгаа юм.

Аллах хэд вэ? Цор ганц.

Чиний шашин юу вэ? Ислам шашин.

Судар чинь юу вэ? Куран Кэрим.

Киблэ чинь юу вэ? Ариун Ка'бэ.

Бид хэний үр сад? Гэгээн Адэм.

Бид хэний үммэт вэ? Гэгээн Мухаммэд (с.а.с)

Түүний эцгийн нэр хэн бэ? Абдуллах

Түүний эхийн нэр хэн бэ? Аминэ.

Түүний сүүн эхийн нэр хэн бэ? Халимэ.

Түүний өвөөгийн нэр хэн бэ? Абдулмутталиб.

Түүнийн авга ахын нэр хэн бэ? Эбу Таалиб.

Гэгээн Элч маань хаана төрсөн бэ? Ариун Мэккэд.

Хэзээ төрсөн бэ? М. 571 онд

Гэгээн Элчийн эцэг, эх нь хэзээ нас барсан бэ? Гэгээн Элчийг төрөхөөс 2 сарын өмнө эцэг нь нас барсан. Харин Гэгээн Элчийг 6 настай байхад эх нь нас барсан.

Хэдэн настай байхад нь түүнд Элчийн үүрэг илгээгдсэн бэ? Түүнийг 40 настай байхад элчийн үүрэг илгээгдсэн. Тэрээр 23 жилийн турш Гэгээн Элчийн үүргээ биелүүлсэн.

Гэгээн Элч маань хэдэн насандаа өөд болсон бэ? 63 настайдаа өөд болсон.

Гэгээн Элчийн маань булш хаана байдаг вэ? Мэдинэ хотод байдаг.

Гэгээн Элч маань хэдэн хүүхэдтэй вэ? Долоо хүүхэдтэй.

Охидууд нь: Зэйнэб, Рукиееэ, Үммү Гүлсүм, Фатима.

Хөвгүүд нь: Касим, Абдуллах, Ибрахим. Фатимагаас бусад бүх хүүхдүүд нь, Гэгээн Элчийг амьд байхад нас барсан билээ.

Гэгээн Элчийн эхнэрүүд (гэр бүл) бидний хувьд хэн бэ? Бидний ээж, өөрөөр хэлбэл бүх мусульманчуудын эх гэсэн үг.

Гэгээн Элчийн анхны болон сүүлчийн эхнэрүүдийн нэр хэн бэ? Анхны эхнэр нь Гэгээн Хатижэ, сүүлийн эхнэр нь Гэгээн Айшэ юм.

Гэгээн Элч маань хэдэн ач зээтэй байсан бэ? Гэгээн Хасан, Хүсэйн болон Гэгээн Зэйнэб, Сүкэйнэ хэмээх зээ нартай байжээ.

Эд нар хэний хүүхэд байсан бэ? Гэгээн Али болон Гэгээн Фатимагийн хүүхдүүд.

32 ФАРЗ

Иман буюу Итгэл үнэмшил гэдэг нь: Зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрч, түүнийгээ хэлээрээ илэрхийлэхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл, Гэгээн Элчийн, Аллахын зүгээс авч ирсэн бүх зүйлсийг зүрх сэтгэлдээ (үнэн гэдгийг нь) хүлээн зөвшөөрч мөн энэхүү итгэл үнэмшилээ хэлээрээ илэрхийлэхийг хэлж байгаа юм.

(Аамэнтү) Иман буюу Итгэл үнэмшлийн болзол: 6

1. Аллахын оршин буй болон цор гарц гэдэгт итгэх.
2. Аллахын Мэлэк[1] буюу (Сахиусан тэнгэрүүдэд) итгэх.
3. Аллахын илгээсэн судруудад итгэх.
4. Аллахын элч нарт итгэх.
5. Ертөнцийн төгсгөлийн өдөр болон үхлийн дараа дахин амилан гэдэгт итгэх.
6. Сайн хийгээд муу үйл Аллахаас гэдэгт итгэх.

Исламийн болзол: 5

1. Кэлимэ шахадэт хэлэх.
2. Өдөр бүр 5 удаагийн мөргөл үйлдэх.
3. Рамазан сард мацаг барих.

---

1. МЭЛЭК; Ислам шашинд Мэлэк буюу сахиусан тэнгэр хэмээн гэрэлнээс бүтээгдсэн сүнслэг биетүүдийг нэрлэнэ. Тэд ууж идэхгүй, унтаж амрахгүй мөн эр,эм хүйсийн ялгаагүй зөвхөн Аллахын зарлигуудыг биелүүлэх үүрэгтэй нүгэлгүй цэвэр ариухан биетүүд юм.

4. Зэкат өгөх (Баян хүмүүс жилд нэг удаа эд хөрөнгөнөөсөө тодорхой хэмжээний өглөг өгөх).

5. Өөрт нь Хаж мөргөл үүрэг болох үед Хажжид явах.

Абдэст угаалгын фарз буюу үүрэг : 4

1. Нэг удаа нүүрээ угаах.

2. Гараа тохойтойгоо цуг угаах.

3. Толгойныхоо дөрөвний нэгийг мэсх хийх (илэх).

4. Хөлөө шагайтайгаа цуг угаах.

Гусул угаалгын фарз буюу үүрэг : 3

1. Ахиухан усаар амаа зайлах.

2. Хамрын уг хүртэл ус татаж хамраа цэвэрлэх.

3. Бүтэн биеэ, хуурай газар огт үлдээхгүйгээр угаах.

Тэеэммүмийн фарз буюу үүрэг : 2

1. Эхлээд тэеэммүм хийхээр ниеэт хэлэх.

2. Хоёр гарын алгаа цэвэр шороонд хүргэн нүүрээ арчаад, дахин шороонд хүргээд тохой хүртэлх гараа арчих.

МӨРГӨЛИЙН НИЙТ 12 ФАРЗ БУЮУ ҮҮРЭГ БАЙДАГ

Үүний зургаа нь мөргөлийн дотор, зургаа нь мөргөлөөс гадна.

А. Мөргөлийн фарзууд (Мөргөлөөс гаднах)

1- Хадэстэн Тахарэт: Нүдэнд үл үзэгдэх “Хадэс” хэмээх хийсвэр бохирдлыг абдэст, гусул болон тэеэммүмээр цэвэрлэх.

2- Нэжасэттэн тахарэт: Бие, хувцас болон мөргөл үйлдэх газраа нүдэнд үзэгдэх бодит хир бохирдлоос цэвэрлэх.

3- Сэтр-и аврэт: Ил үзэгдэх нь шашины хувьд үл хүлээн зөвшөөрөгдөх хэсгүүдээ далдлах. Эрчүүдийн хувьд хүйснээс өвдөг хүртэлх хэсэг, харин эмэгтэйчүүдийн хувьд гар, нүүр болон хөлнөөс бусад биеэ бүхэлд нь далдлахыг хэлнэ.

4- Истикбал-и киблэ: Мөргөл үйлдэхээр киблэ зүг чиглэн зогсох.

5- Вакит: Мөргөл бүрийг цагт нь үйлдэх.

6- Ниеэт: Үйлдэх гэж буй мөргөлдөө ниеэт хэлэх.

Б. Мөргөлийн Рукинүүд буюу тулгуур хэсгүүд (Мөргөлийн доторх)

1. Ифтитах тэкбир: Мөргөлөө (Аллах-у Экбэр) хэмээн эхлэх.

2. Кияам: Мөргөл үйлдэх үед (хүндэтгэх шалтгаан байхгүй бол) хөл дээрээ зогсох.

3. Кираат: Мөргөлдөө Куран Кэрим унших.

4. Рүкү: Рүкүд очих (хагас бөхийх).

5. Сүжуд: Сэждэд очих (сөгдөн мөргөх).

6. Ка'дэ Ахирэ (Сүүлчийн суулт): Мөргөлийн төгсгөлд "Эттэхияяату"г унших хэмжээнд суухыг хэлнэ.

Фарз: Аллах Эзэний зүгээс хийхийг зарлиг болгосон зүйлсийг фарз хэмээн нэрлэдэг. "Мөргөл, Мацаг, Зэкат... гэх мэт." Фарзуудыг үйлдэхгүй байх нь хараамд тооцогдоно. Фарзыг үгүйсгэсэн хэн нэгэн шашинаас гарсанд тооцогдоно.

Сүннэт: Бидний Хайрт Элч Мухаммэдийн (с.а.с) ибадэт буюу шашины зан үйлийн зорилгоор ихэнхдээ үйлдэж, хааяа орхигдуулдаг байсан мөн бид бүхэнд үйлдэхийг зөвлөсөн үг болон үйлдлүүдийг сүннэт гэж нэрлэдэг.

Хараам: Үйлдэхийг хориглосон зүйлсийг хараам гэж нэрлэдэг. Тухайлбал: Архи болон согтууруулах төрлийн ундаа хэрэглэх, мусульман эмэгтэйчүүд гадны эрэгтэйчүүдийн дэргэд толгой нүцгэн байх... гэх мэт. Хараамыг үйлдэхгүй байх аваас буян хураах болно. Хараам гэдгийг нь мэддэг хирнээ үгүйсгэсэн хүн шашинаас гарсанд тооцогдоно.

Бие Засах Газрын Ариун Цэвэр

➢ Бие засах өрөөнд орохдоо шээс үсрэхээс сэргийлэн өмд болон хормойгоо дээш шуух хэрэгтэй. Эрэгтэйчүүд зогсоогоороо бие засахгүй байх нь зүйтэй.

➢ Бие засах өрөөнд ямар нэгэн зүйл идэж уух, ярилцахыг хориглоно.

➢ Бие засах өрөө рүү зүүн хөлөөрөө орж, баруун хөлөөрөө гарна.

Бие засах газрын ариун цэвэр: Бие зассаны дараа зүүн гараар ахиухан ус авч угаан цэвэрлэх хэрэгтэй. Хэрэв ус байхгүй тохиолдолд боломжын зүйлс ашиглан сайтар арчин цэвэрлэх хэрэгтэй. Мөргөл үйлдэж буй мусульман хүмүүс энэ төрлийн цэвэрлэгээг сайтар сахих хэрэгтэй.

Абдэст Угаалга

Абдэст угаалга гэдэг нь; Нүүр, гар болон тохой, хөл болон шагайг оролцуулан угааж, толгойны дөрөвний нэгтэй тэнцэх хэсгийг мэсх (нойтон гараар илэхийг) хийхийг хэлж байгаа юм.

Абдэст угаалга үйлдэх байдал: Боломжтой бол киблэ (мөргөл үйлдэх зүг) рүү чиглэн зогсоод, “Абдэст угаалга үйлдэхээр ниеэт хэлж байна, Эгүзү-биллахи-минэш-шэйтаанир-ражим Бисмиллаахир-рахмаанир-рахийм.” гэж хэлнэ.

Дараа нь, дэс дараалллуулан эхлээд гараа гурван удаа угаана. Гар угаах үедээ хуруу хооронд хуурай хэсэг үлдээхгүй байхыг анхаарах хэрэгтэй. Хэрэв бөгж зүүсэн бол эргүүлэх маягаар доогуур нь ус оруулна.

Дараа нь, баруун гарын алгаар ус авч амаа сайтар зайлна. Үүнийг гурван удаа давтах хэрэгтэй. Сойз байвал сойзоор, байхгүй тохиолдолд баруун гарын эрхий аль эсвэл долоовор хуруугаар шүдээ цэвэрлэнэ.

Дараа нь хамартаа гурван удаа баруун гараар ус өгч, зүүн гараар нийж цэвэрлэнэ.

Нүүрээ, үсний уг хэсгээс эхлүүлэн эрүүний ясыг оролцуулан гурван удаа угаана.

Дараа нь тохойг оролцуулан эхлээд баруун гараа, дараа нь зүүн гараа гурван удаа угаана.

Толгойны дөрөвний нэгтэй тэнцэх хэсгийг баруун гарын алгаар мэсх (илэх) хийнэ.

Түүний дараа долоовор хуруугаар чихний нүх, эрхий хуруугаар чихний ар талыг мэсх хийнэ.

Мөн гарын ар хэсгээр хүзүүг мэсх хийнэ.

Тэгээд баруун хөлийн чигчий хуруунаас эхлэн, эхлээд баруун дараа нь зүүн хөлөө шагайтай нь цуг гурван удаа угаана.

Ийнхүү абдэст авч дууссаны дараа баруун гараар ус авч, зогсоогоороо уух нь сүннэт юм.

Абдэст авч дууссаны дараа, киблэ (мөргөл үйлдэх) зүг чиглэн "Кэлимэ-и шэхадэт" хэлэх аль эсвэл гурван удаа "Инна энзэлнаахү" бүлгийг унших нь маш буянтайд тооцогдоно.

Абдэст угаалгын фарзууд:

1- Нүүрээ нэг удаа угаах,

2- Гараа тохой оролцуулан нэг удаа угаах,

3- Толгойны дөрөвний нэгтэй тэнцэхүйц хэсгийг мэсх хийх,

4- Хөлөө шагайтай нь цуг нэг удаа угаах.

Абдэст угаалгын сүннэтүүд:

1- Абдэст угаалга үйлдэхээр ниеэт хэлэх (завдаж буйгаа илэрхийлэх),

2- Э'үзү Бэсмэлэгээр эхлэх,

3- Эхлээд гараа бугуй хүртэл угаах,

4- Амаа сойз аль эсвэл баруун гарын долоовор болон эрхий хурууны аль нэгээр цэвэрлэх,

5- Эхэлж угаасан хэсэг нь хатахаас өмнө бусад хэсгээ угаах,

6- Угааж буй хэсгээ сайтар үрж угаах,

7- Амандаа ус өгч гаргах маягаар гурван удаа зайлах,

8- Мацаг барихгүй байгаа бол, амаа усаар дүүргэн сайтар зайлах,

9- Хамартаа баруун гараараа гурван удаа ус өгч, зүүн гараараа нийх, мацаг барихгүй байгаа бол хамрын самалдаг хүртэл сайтар татах,

10- Абдэс авах үедээ дэс дараалլыг баримтлах,

11- Бүх хэсгийг гурван удаа угаах,

12- Гар болон хөлөө угаахдаа хуруунаас нь эхлэх,

13- Хурууны завсруудыг сайтар угаах,

14- Өтгөн сахалтай хэн нэгэн, хуруугаараа сахлаа сайтар үрж угт нь ус хүргэх,

15- Гартаа бөгжтэй бол эргүүлэн хөдөлгөж завсраар нь ус оруулах,

16- Хоёр чихээ мэсх хийх.

Абдэст угаалгыг хүчингүй болгох зүйлс:

1- Ичимдэг эрхтнээс гарах өтгөн, шингэн ялгадас болон хий (унгас).

2- Биеийн аль нэг хэсгээс цус, идээ, шар ус, цустай холилдсон ус гарах.

3- Ам дүүрэн бөөлжих (Цэр гаргахад эвдрэхгүй).

4- Амнаас шүлсний хэмжээтэй аль эсвэл илүү их хэмжээтэй цус гарах.

5- Хэвтэж аль эсвэл ямар нэг зүйл түшиж унтах.

6- Ухаан алдах, согтох.

7- Мөргөл үйлдэх үедээ дэргэдэх хүнд сонсогдохуйц инээх.

8- Хумсны будаг нь дотогшоо ус нэвтрүүлдэггүй учраас абдэст угаалга болон гусул (бүтэн биеийн угаалга) үйлдэхэд саад болно. Бүрэн гүйцэт цэвэрлэсний дараагаар угаалга үйлдэх хэрэгтэй.

Абдэст угаалга үйлдэхгүйгээр хийж эс болох ибадэтүүд (шашины зан үйлүүд):

1- Мөргөл үйлдэж болохгүй.

2- Куран Кэримд гар хүрч болохгүй.

3- Ка'бэг таваф (ка'бэг тойрох шашины зан үйл) хийж болохгүй.

4- Тилавэт сэждэ (Кураны сэждэ ишлэлийг унших буюу сонсох үе хийх сэждэ) үйлдэж болохгүй.

ТЭЕЭММҮМ

Тэеэммүм гэдэг нь ямарч усгүй үед эсвэл ямарваа нэгэн шалтгааны улмаас ус ашиглах боломжгүй үед цэвэр шороо болон шорооны төрлийн зүйлд гараараа үрж хийх хуурай ариутгал юм.

Тэеэммүмийг үйлдэх байдал: Э'үзү Бэсмэлэг хэлнэ. Абдэст аль эсвэл жүнүб (эр, эмийн харьцаанд орох аль эсвэл нойтон зүүд зүүдэлэх нь жүнүбэд тооцогдоно.) байдлаас цэвэрлэгдэхээр ниеэт хэлж байна" хэмээн ниеэт хэлнэ. Дараа нь гарын хуруунуудаа дэлгэн алган хэсгээр нь цэвэр шороо аль эсвэл шорооны төрлийн зүйлд хөнгөхөн, эхлээд урагшаа дараа нь хойш нь буцаан үрнэ.

Тэмдэглэл: Эрэгтэй болон эмэгтэй хүмүүсийн тэеэммүм хийх байдал адилхан болно.

Гараа эхлээд урагш нь, дараа нь хойш үрнэ.

Тэеэммүмийн фарзууд:

1) Ниеэт хэлэх: "Ниеэт хэлж байна, абдэст авахаар аль эсвэл жүнүбээс цэвэрлэгдэхийн тулд аль эсвэл мөргөл үйлдэхийн тулд" хэмээн ниеэт хэлнэ.

2) Хоёр цохилт: Эхлээд хоёр гараа, цэвэр шороонд цохин нүүрээ мэсх хийх, дараа нь гараа дахин газар цохиж гарыг тохойтой нь цуг мэсх хийнэ.

Сүннэтүүд:

1) Бэсмэлэгээр эхлэх

2) Хоёр гарын хуруунуудыг салгасан байдалтайгаар шороонд дээр тавих,

3) Хоёр гарыг нааш цааш үрэх,

4) дэс дарааллыг баримтлан, хооронд нь завсардуулалгүйгээр ар араас нь тэеэммүм хийх.

Гараа өргөн хооронд нь зөөлхөн цохиж сэгсрэх.





Нүүрээ бүхэлд нь хоёр гарын алгаараа мэсх хийх.

Дараа нь алгаа дахин ижил байдлаар шороонд үрнэ. Эхлээд зүүн гарын эрхий болон долоовор хурууг салган үлдсэн гурван хуруугаар баруун гарын дотор хэсгийг гарын үзүүрээс тохой хүртэл мэсх хийнэ.

Дараа нь баруун гарын гаднах хэсгийг зүүн гарын салгасан эрхий болон долоовор хуруугаар мэсх хийнэ.



Ижил байдлаар баруун гараа ашиглан зүүн гараа мэсх хийнэ.



Дараа нь баруун гарын эрхий болон долоовор хуруугаар зүүн гарын ар хэсгийг мэсх хийнэ.

Ийнхүү нүүр болон гарыг нэг бүрчлэн мэсх хийснээр фарз болон сүннэтийн дагуу тэеэммүм хийсэнд тооцогдож байгаа юм.

Тэеэммүмийг *Зайлшгүй Хийх Шалтгаанууд:*

Абдэстгүй, жунүб, сарын тэмдэг ирсэн болон нифас (төрсний дараах 40 хоног) хүмүүс доорх шалтгаанаас үүдэн тэеэммүм хийж болно.

1- Ус нэг милл (ойролцоогоор: 3.032 митр) хэмжээнд хол байгаа бол,

2- Өвчний улмаас,

3- Хэтэрхий хүйтнээс болж,

4- Дайсны аюул хөнөөлөөс эмээх,

5- Уух усгүй үлдэх аль эсвэл ядуугаасаа болж цэвэр ус хэрэглэх боломжгүй хэцүү үед тэеэммүм хийж болно. Хот хөдөө ялгаагүй эдгээр тохиолдлуудад тэеэммүм хийж болно.

Тэеэммүм хийж буй хүн, бөгж болон бугуйвчаа тайлах аль эсвэл эргүүлэн хөдөлгөх хэрэгтэй.

ГУСУЛ УГААЛГА

***Гусул* гэдэг нь:** Биеийг бүхэлд нь угаахыг хэлж байгаа юм.

Гусул угаалгын фарз нь: 3

1- Мазмаза: Амандаа ахиухан ус авч, хоолойн уг хүртэл сайтар зайлах.

2- Истиншак: Хамрын уг хүртэл ус татаж цэвэрлэх.

3- Биеийн бүх хэсгийг зүүний үзүүрийн төдий хуурай газар үлдээхгүйгээр угаах.

Мазмаза хийхийн тулд, ам дүүрэн ус уух нь мөн хангалттайд тооцогддог.

***Гусул* угаалгын *суннэтүүд*:**

1- Гараа бугуйтай нь цуг гурван удаа угаах,

2- Ичимдэг эрхтэнгүүдээ угаах,

3- Биеийн аль нэг хэсэгт бохир зүйл байгаа бол түүнийг угааж цэвэрлэх,

4- Мөргөл үйлдэх үед хийдэг шигээ абдэст угаалга үйлдэх,

5- Бүтэн биеэ гурван удаа угаах,

6- Гусул авахаасаа өмнө эхлээд толгойдоо гурван удаа, дараа нь баруун мөрөндөө гурван удаа, дараа нь мөн гурван удаа зүүн мөрөндөө ус өгөх маягаар биеийн бусад хэсгээ усаар зайлах,

7- Зүрх сэтгэлээсээ ниеэт хэлж эхлэх мөн хэлээрээ “жүнүб байдлаас цэвэрлэгдэж байгаагаа өөрөөр хэлбэл жүнүб болсон учраас гусул угаалга үйлдэе” хэмээн ниеэт болгон хэлэх,

8- Гараа угаахдаа бэсмэлэ хэлэх,

9- Усыг зохих хэмжээнд хэрэглэх, хэт их аль эсвэл хэт бага хэрэглэхгүй байх,

10- Гусул угаалга үйлдэх үедээ аврэт хэсгээ (доод хэсгээ) дэлгэхгүй байхыг анхаарах. Ялангуяа бие засах газар маш сайн анхаарах хэрэгтэй.

11- Угаах үедээ биеийн бүх хэсгийг сайтар үрэх,

12- Гусул үйлдэх үедээ хүнд харагдахааргүй далд газар усанд орох,

13- Гусул үйлдэх үедээ хэн нэгэнтэй ямар нэг зүйл ярихгүй байх нь зохимжтой.

14- Гусул үйлдэх үедээ киблэ зүг рүү чиглэн харахгүй байхыг анхаарах.

Фарз болон сүннэтүүдийг баримтлан, ёс жаягын дагуу гусул угаалга үйлдэх:

Гусул угаалга үйлдэхийг хүссэн хүн эхлээд залбирал маягаар Бэсмэлэг хэлж дараа нь гусул үйлдэхээр ниеэт хэлэх хэрэгтэй. Гараа бугуй хүртэл угааж, хатсан наалдсан бохир зүйлс байгаа бол угаана, дараа нь доод хэсэг болон гуя ташаанд бохир зүйл байсан байгаагүй ч сайтар угаана.

Үүний дараа баруун гараараа ус авч шүдний завсар болон хоолойн уг хүртэл гурван удаа сайтар зайлна. Дараа нь дахин баруун гараараа ус авч хамартаа ус татан дотор нь хатуу нус болон бусад зүйлс үлдээхгүйн тулд зүүн гараараа нийх хэрэгтэй. Үүнийг мөн гурван удаа хийнэ.

Үүний дараа мөргөл үйлдэхдээ авдаг абдэст угаалга шиг абдэст угаалга хийнэ. Хэрэв зогсож байгаа газарт нь ус хуримтлагдаж байгаа бол хөлөө заавал угаах шаардлагагүй, уснаас гарахдаа угаахад болно. Абдэст угаалга үйлдэснийхээ дараа, эхлээд толгой, дараа нь баруун дараа нь зүүн мөрөндөө гурван удаа ус урсган биеэ угаана. Хуйхандаа ус хүргэхийн тулд хуруугаараа

сайтар үрэх хэрэгтэй. Хэрэв биеийн аль нэг хэсэгт гарсан шарханд эм түрхсэн байгаа тохиолдолд, түрхсэн эмийг арилгах нь шарханд ямар нэгэн хор нөлөөгүй бол дээгүүр нь ус урсгах хэрэгтэй. Харин хор нөлөөтэй бол тэр хэсгийг мэсх хийнэ. Хэрэв мэсх хийх нь хор нөлөө үзүүлэхээр бол зөвхөн боолтных нь гаднаас мэсх хийхэд хангалттай.

Гусул угаалгын ач холбогдлууд:

Гусул угаалга нь, хүний бие дэхь эрчим хүчний тэнцвэрийг бий болгож өгдөг. Цусны эргэлт болон даралтыг хэвийн хэмжээнд байлгаж, арьсны нүх сүвнүүдэд чөлөөтэй агаар амьсгалахад нь тусалдаг байна.

Гусул угаалга үйлдэх шаардлагатай байдлууд:

Эмэгтэйчүүд сарын тэмдэг болон төрсний дараах 40 хоног өнгөрсний дараа, харин эрэгтэйчүүд жунүб болсон бол гусул угаалга үйлдэх шаардлагатай.

Эмэгтэйчүүд гусул угаалга үйлдэх үед үсний хуйханд ус хүрч байгаа л бол сүлжсэн үсээ заавал задлах шаардлагагүй. Сүлжсэн үстэй эмэгтэй хүн зөвхөн хуйхыг нь угаахад хангалттайд тооцогдоно. Харин үсээ сүлжээгүй тохиолдолд бүхэлд нь угаах нь фарз юм.

Гусул авах үед бөгжөө хөдөлгөх, эмэгтэйчүүд ээмгээ хөдөлгөн ус оруулах хэрэгтэй.

45-50 $м^2$ хэмжээний тогтмол усанд, усан санд ам болон хамартаа ус өгсний дараа бүтэн биеэ гурван удаа хөдөлгөхөд гусул авсанд тооцогдоно.

Хэн нэгэн урсгал усанд орох аваас биеэ хөдөлгөөгүй ч гэсэн абдэст болон гусул угаалга авсанд тооцогдоно.

Хумсны завсар хэсэг болон дээр наалдаж хумс болон арьсанд ус хүрэхэд саад болохуйц гурил болон хумсны будаг гэх мэт зүйлс нь гусул угаалга хүчинтэй болоход саад болно.

Жүнүб болсон хүний хийх хориотой зүйлс:

1. Жүнүб болсон мөн сарын тэмдэг ирсэн аль эсвэл төрсний дараах 40 хоног дуусаагүй тохиолдолд, жаами (Исламын сүм) рүү орж болохгүй.

2. Куран уншихгүй.

3. Куран Кэрим барьж болохгүй.

4. Ка'бэг таваф (ка'бэг тойрох зан үйл) хийхгүй.

5. Мөргөл үйлдэхгүй.

6. Мацаг барихгүй.

Эмэгтэйчүүдтэй холбоотой онцгой байдлууд:

1. Сарын тэмдэг,

2. (Лохуса),Төрсний дараах 40 хоногт ирэх цус,

3. Хүндэтгэх шалтгаан (цус ирэх), гэх мэт зүйлсийг сурч мэдэх нь бүх эмэгтэйчүүдийн хувьд фарз юм. Мэдэхгүй эмэгтэйчүүдэд нөхөр нь аль эсвэл гэр бүлийнхэн нь сурч мэдсэнийхээ дараа, зааж өгөх хэрэгтэй.

Тэмдэглэл: Эмэгтэйчүүдтэй холбоотой онцгой нөхцөл байдлуудын талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл: Асим Уясал-Мүршидэ Уясал-ын *“Эмэгтэйчүүдийн талаарх шашины дүрмийн тайлбар толь”* хэмээх номыг харж болно.

АЗАН/МӨРГӨЛИЙН ДУУДЛАГА

4 удаа ***Аллаху Экбэр:*** Аллах хамгийн агуу нь.

2 удаа ***Эшхэдү энлаа илаахэ иллаллаах:*** Би Гэрчилж байна, Аллахаас өөр бурхан үгүй.

2 удаа ***Эшхэдү эннэ Мухаммэдэр-расуулуллаах:*** Би гэрчилж байна, Мухаммэд Аллахын элч.

2 удаа ***Хаяяа а'лэс-салаах:*** Алив мөргөлдөө.

2 удаа ***Хаяяа а'лэл-фэлаах:*** Алив аврагдацгаая.

2 удаа ***Аллаху Экбэр:*** Аллах хамгийн агуу нь.

1 удаа ***Лаа илаахэ иллаллаах:*** Аллах цор ганц бөгөөд Түүнээс өөр Эзэн гэж үгүй.

Өглөөний мөргөлд, *"Хаяяа а'лэл-фэлах"* гэж хэлснийхээ дараа 2 удаа ***Ас-салаатү хаярүн минэннэвм:*** (Мөргөл нойрноос илүү буянтай) хэмээн хэлнэ.

Камэтэд, *Хаяяа а'лэл-фэлаах* гэж хэлснийхээ дараа хоёр удаа ***(Кад каамэтис-салаах)*** гэж хэлнэ.

Камэтыг хурдан уншина. Харин Азаныг ойр тойрны мусульманчуудад сонсгох зорилгоор удаан, чанга дуугаар унших хэрэгтэй.

Аллахүммэ Раббэ хаазихид-да'вэтит-тааммэти вэссалаатил-каа-имэти аати Мухаммэдэннил-вэсийлэтэ вэл-фазийлэтэ вэддэрэжэтэр-рафий-атэ вэб'ас'хү макаамэн махмуудэн-ниллэзий вэ ад'тэх, иннэкэ лаа тухлифүл-миаад.

Өгүүллэг: Аллах Эзэн биднээс юу хүсдэг вэ?

Ахмэтийн аав нь цэцэрлэгчин юмсанж. Тэрээр нэгэн өдөр аавдаа тусалж байв. Аав нь:

- Хүү минь нэг аяга ус аваад ирээч? гэв

Аав нь ус ууж байх хооронд мөргөлийн дуудлага дуудаж эхлэв.

- Баярлалаа хүү минь! Чи хүссэн зүйлийг минь хийлээ. Харж байна уу? Харин одоо Аллах биднээс ямар нэг зүйл хүсч байна.

Ахмэт, нүдээ бүлтийлгэн аав руугаа харав:

- Аллах биднээс ямар нэг зүйл хүсч байна гэсэн үү, аав аа?

- Тиймээ миний хүү.

- Гэхдээ би юу ч сонсохгүй байна!

- Мөргөлийн дуудлагыг сонсож байгаа биз дээ!

- Тийм ээ, Гэхдээ...

- Хүү минь! Аллах биднээс хүсэж байгаа зүйлээ янз бүрийн байдлаар илэрхийлж байдаг юм. Жишээлбэл мөргөлийн дуудлага, мусульман хүмүүст Аллах Эзэний “Мөргөлөө үйлдэгтүн!” хэмээх зарлигийг сануулж байдаг. Бид мөргөлийн цаг бүрт энэхүү зарлигийг сонссон мэт болдог юм.

М. Яашар Кандэмир

Мөргөл Бидний Хөсөр Орхихгүй

Мөргөл биднийг хөсөр орхихгүй, өдөр бүр мөргөл үйлдэх ёстой,

Мусульман хүн мөргөлөө нэг өдөр ч болов орхигдуулах ёсгүй.

Өглөө, их үд, бага үд, орой, шөнө таван удаа,

Мөргөлд зогсон дотоод хир буртгаасаа сал!

Мөргөл үйлддэг хүмүүсийн дотор гэрэл гэгээ дүүрч байдаг,

Мөргөл эс үйлдэгч хүний нүүрний гэрэл гэгээ бүдгэрч байдаг.

Мөргөл гэдэг нь, Аллахын өмнө залрах гэсэн үг,

Аллахтай ярилцах гэсэн үг, Түүний гэрэл гэгээнд хүрэх гэсэн үг.

Цаг алдалгүй абдэст үйлдэн, цэвэр ариун бологтун;

Хүүхдийг багаас нь ариун цэвэрт сургахтун;

Цэвэрхэн байх аваас өвчин тусахгүй эрүүл саруул байна,

Хэн цэвэрхэн байна, тэр эрүүл саруул, инээмсэглэн амьдрах болно.

М.Ш. Яалткаяа

Доорх сэдэвт ашиглагдах үгсийн тайлбар

Киблэ: Мөргөл үйлдэх зүг, ариун Каабэ.

Киям: Мөргөл үйлдэх үедээ хөл дээрээ цэх зогсох.

Кират: Мөргөл үйлдэх үед Кураны зарим ишлэл болон бүлгээс унших.

Рэкат: Тухайн мөргөлийн киям, руку болон хоёр сэждэгийн нэгдэл.

Руку: Өвдөгөө даран хагас бөхийх.

Кавмэ: Руку байдлаас өндийж цэх зогсохыг хэлнэ.

Сэждэ: Дух болон магнайгаа газарт хүргэн сөгдөн мөргөх.

Жэлсэ: Хоёр сэждэгийн хоорондох суултыг хэлнэ.

МӨРГӨЛ

Мөргөл үйлдэхгүй байхын шийтгэл:

Гэгээн Элч (с.а.с) нэгэн хадистаа:

“Мөргөл үйлдэхгүй байх нь, үл итгэл болон ширк хоёрын хоорондох байдал юм. Өөрөөр хэлбэл, мөргөл үйлдэхгүй байх явдалд нь үл итгэлд хүргэх зам болдог. Мөргөл үйлдэхгүй байх явдалд үл сүсэглэлд (шашин үл шүтэх байдалд) хүргэх нэгэн зам бий. хэмээн айлдсан байдаг.

Ислам шашинд мөргөлийг орхигдуулах гэсэн ойлголт огт байдаггүй. Өвдсөн хэн нэгэнд хүртэл мөргөлөө орхигдуулахыг зөвшөөрөөгүй байдаг. Хүнд өвчтэй хүмүүс

мөргөлөө хэрхэн үйлдэх талаар дараа тайлбарлах болно. Ислам шашинд дайн тулаан болж байсан ч мөргөлийг орхигдуулдаггүй. Мөргөл үйлдэхгүй байхын шийтгэл гэж байдгын адил, мөргөлөө зүй ёсоор нь үйлдэхгүй байсны хүнд шийтгэл гэж бас бий. Мөргөлийн хулгайчид; Имамаас өмнө үйлдэл хийгсэд, руку болон сэждэд хангалтгүй тонгойгсод... гэх мэт дурьдсан байдаг.

Өөр нэгэн хадист Гэгээн Элч ийнхүү айлдсан байдаг.

“Хүмүүсийн дотроос хамгийн жигшүүртэй хулгайч нь, мөргөлөөсөө хумслагчид юм.”

Өдөр тутмын таван удаагийн мөргөлүүд болон тоо:

1- Өглөөний мөргөл: Хугацаа нь, нар мандах хүртэл үргэлжилнэ. Нийт 4 рэкат. 2 рэкат сүннэт, 2 рэкат фарз.

2- Их үдийн мөргөл: Хугацаа нь, нар эгц дээрээс жаргах зүгрүү чиглэсэн үеэс эхлэнэ. Нийт 10 рэкат. 4 рэкат эхний сүннэт, 4 рэкат фарз, 2 рэкат сүүлчийн сүннэт.

3- Бага үдийн мөргөл: Хугацаа нь, бүх зүйлсийн сүүдэр 2 дахин урт болох хүртэл: Нийт 8 рэкат. 4 рэкат сүннэт, 4 рэкат фарз.

4- Оройн мөргөл: Хугацаа нь, Нар жаргасны дараах үе. Нийт 5 рэкат. 3 рэкат фарз, 2 рэкат сүннэт.

5- Шөнийн мөргөл: Оройны мөргөлийн цаг дууссанаас эхлээд өглөөний мөргөлийн цаг орох хүртэл үргэлжилнэ. Нийт 13 рэкат. 4 рэкат эхний сүннэт, 4 рэкат фарз, 2 рэкат сүүлчийн сүннэт, 3 рэкат Витир мөргөл. (Витир мөргөл нь важиб юм.)

Фарз мөргөлүүд: Аллах Эзэний зарлиг болгосон мөргөлүүд.

Сүннэт мөргөл нь: Гэгээн Элчийн зарлиг болон сургамж болгосон мөргөлүүд.

Важиб мөргөлүүд: Важиб мөргөл нь фарз болон сүннэт мөргөлийн дундах түвшин юм.

Витир мөргөл: шөнийн мөргөлийн дараа үйлдэгдэх гурван рэкат мөргөл юм.

Нафилэ мөргөлүүд: Аллахад илүү ойр дотно байхын тулд үйлдэх мөргөлүүд.

Мөргөл Үйлдэхэд Хориотойд Тооцогдох Цагууд

1- Нар мандаж байх үед: Өглөөний мөргөлөө үйлдэж байх үед нар мандаж эхлэх аваас тухайн мөргөл хүчингүйд тооцогдоно.

2- ***Зэваал хугацаа:*** Өөрөөр хэлбэл их үдийн мөргөлийн цаг орохын өмнөх 45 минут. Нар эгц дээр байх үе.

3- ***Гуруб хугацаа:*** Өөрөөр хэлбэл нар жаргаж байх үе. Оройны мөргөлийн цаг орохоос өмнөх 45 минут.

Гэхдээ нар жаргаж байх энэ хугацаанд тухайн өдрийн бага үдийн мөргөлийг үйлдэх нь зөвшөөрөгдсөн байдаг.

Өглөөний Мөргөлийн Сүннэтийг Хэрхэн Үйлдэх Тухай

1. Рэкат

Абдэст угаалга үйлдэн киблэ чиглэн, хөл дээрээ цэх зогсоод ийнхүү ниеэт хэлнэ.

“Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө өглөөний мөргөлийн сүннэтийг үйлдэхээр” фарзыг уншихдаа, “фарзыг” хэмээн ниеэт хэлнэ.



Мөргөлийн зогсолт болон ниеэт хэлэх байдал:

1) Рэкатыг эхлэх үед биеэ сул чөлөөтэй тавьж, нүдээ сэждэ хийх газарт чиглүүлж, хоёр хөлийн хооронд 4 хуруу хэмжээтэй зай үлдээсэн байх хэрэгтэй.

Тэкбир **авах байдал**

2) Ниеэт хэлсний дараа *“Аллаху Экбэр”* хэмээн хоёр гараа чихний хэмжээнд өргөнө. Гарын алгаа аль болох киблэ зүг рүү харуулах хэрэгтэй. Дараа нь гараа чихний хэмжээнээс авч, гэдэсний доод хэсэгт холбон барина.



Эмэгтэйчүүд хурууны үзүүр хэсгээ мөрний хэмжээнд өргөж тэкбир хийнэ.

Кияам болон Кираат

3) Тэкбир авсны дараа, баруун гараа зүүн гарын дээр тавьж, баруун гарын эрхий хуруу болон чигчий хуруугаар зүүн гарын бугуйгаар бүслэн барина.



Эмэгтэйчүүд, тэкбир авсны дараа хуруугаа салгалгүйгээр хоёр гараа энгэр дээрээ тавина.

4) Хоёр гараа цээжин дээрээ холбон барисныхаа дараа, аяархан дуугаар Сүбхаанэкэг ийнхүү уншина: ***Сүбхаанэкэ'л-лаахүммэ вэ бихамдик. Вэ тэбаарокэсмүк. Вэ тэ'аалаа жэддүк. Вэ лаа илаахэ гайрүк.***

5) Дараа нь; Э'үзү-Бэсмэлэ болон хойноос нь Фатиха бүлгийг ийнхүү уншина:

Э'үзү биллаахи минэш-шэйтаанир-ражийм

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм. Элхамдү лиллаахи Роббил-аалэмийн. Эр-Рахмаани'р-Рахийм. Маалики еэвмид-дийн. Ияяаакэ на'бүдү вэ ияяаакэ нэста-ийн. Ихдина'с-сыроото'л-мүстакийм. Сироотол-лэзийнэ эн'амтэ алэйхим, гайри'л-магдууби алэйхим вэ лэд-дооллийн.

6) *Фатихагийн* дараа нэгэн богино бүлэг эсвэл ишлэл уншиж болно. Жишээлбэл:

Иннаа а'тоянаа кэл-кэвсэр. Фэ-солли ли-Роббикэ вэнхар, иннэ шааниэкэ хүвэл-эбтэр.

РУКҮ

7) Үүний дараа, мөн *"Аллахү Экбэр"* хэмээн рукүд очино. Рукүд толгой болон нуруу нэгэн хэмжээнд, нуруугаа тэгшлэн нүд хөлийн хурууны үзүүр хэсэг рүү харсан байдалтайгаар, өвдөгөө нугалалгүй, гарын алга хэсгээр өвдөгөө барина. Энэ байрлалд *"Субхаан Рабби-Яэл-Азым"* гэж 3,5,7 удаа хэлнэ.

Харин эмэгтэйчүүд; рукүд очихдоо эрэгтэйчүүдээс арай бага хэмжээнд бөхийнө. Өвдөгөө бага зэрэг нугалан хуруунуудаа салгалгүйгээр гараа өвдгөн дээрээ тавина.

Кавмэ: Рукү байдлаас өндийж цэх зогсохыг хэлнэ.

8) Рукүгээс өндийх үедээ *“Сэми-Аллахүлимэн хамидэ”* цэх зогссоныхоо дараа *“Раббэна лэкэл хамд”* гэж хэлнэ. Хэсэг зогсоод дараа нь *“Аллаху Экбэр”* хэмээн сэждэд очино.

СЭЖДЭ

9) Сэждэд очихдоо эхлээд өвдөг, дараа нь гар, түүний дараа дух болон хамараа газарт хүргэнэ. Хуруунуудын хооронд зай гаргалгүйгээр, гар болон нүүрээ нэг хэмжээнд тавина. Хоёр хөл нийлсэн байдалтай байна. Хөл газраас хөндийрөх ёсгүй. Гар болон хөлийн хуруунууд киблэ зүг чиглэсэн байх ёстой. Өвдөг гэдэснээс хол, тохой; газар болон гэдсэнд наалдах ёсгүй.

Харин эмэгтэйчүүд, сэждэ хийхдээ тохойгоо газарт хүргэн, гэдэсээ өвдгөндөө ойрхон байрлуулна. Сэждэд гурван удаа ***“Сүбхаанэ рабби-яэл-алаа”*** гэж хэлнэ.

10) Дараа нь сэждэгээс ***“Аллаху Экбэр”*** хэмээн өндийн сууна. Энэхүү суултыг *“Жэлсэ”* гэж нэрлэдэг.

Энэ үед зүүн хөлөө баруун тийш хэвтүүлэн тавьж дээр нь сууна. Баруун хөлийн хуруунуудаа киблэ чиглүүлэн нугалж тавина. Хоёр гараа өвдгөн дээрээ тавиад нэг удаа *"Сүбхааналлах"* гэж хэлэх хэмжээнд сууна.

Харин эмэгтэйчүүд суухдаа баруун хөлийн хуруунуудаа нугалахгүйгээр хоёр хөлөө хоёуланг нь баруун тийш нь хэвтүүлэн тавьж сууна. Дараа нь ***"Аллаху Экбэр"*** хэмээн хоёрдахь сэждэд очино. Мөн гурван удаа ***"Сүбхаанэ Рабби-яэл-ала"*** гэж хэлнэ.

2. ДАХЬ РЭКАТ

11) Дараа нь ***"Аллаху Экбэр"*** хэмээн (дэс дараалллулан эхлээд духаа, дараа нь гараа, дараа нь өвдөгөө салгана) босч, 2 дахь рэкатад зогсоно. Гараа

холбон кияамд зогсоно. Ийнхүү өглөөний мөргөлийн сүннэтийн эхний рэкат дуусч хоёр дахь рэкат эхэлнэ.

2. Рэкат кияам болон кираат

Хоёрдахь рэкатад "Сүбхаанэкэг" уншихгүй. Гараа холбон зогсоод: Бисмиллаахир-рахмаанир-рахийм. гэж хэлнэ. Дараа нь эхний рэкатад уншсаны адил фатиха бүлгийг уншаад хойноос нь өөр нэгэн бүлэг аль эсвэл ямар нэгэн ишлэл уншина.

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм. Элхамдү лиллаахи Роббил-аалэмийн. Эр-Рахмаанир-Рахийм. Маалики еэвмид-дийн. Ияяаакэ на'бүдү вэ ияяаакэ нэста-ийн. Ихдина'с-сыроото'л-мүстакийм. Сироотол-лэзийнэ эн'амтэ алэйхим, гайри'л-магдууби алэйхим вэ лэ'д-дооллийн.



ИХЛААС БҮЛЭГ: Кул хүваллаахү эхад. Аллаахү'с-сомэд. Лэм яэлид вэ лэм юүүлэд. Вэ лэм яэкүллэхүү күфүвэн эхад.

РУКҮ

12) Дараа нь ***“Аллаху Экбэр”*** хэмээн рукүд очно. *Рукүд* 3 удаа ***“Сүбхаанэ Рабби-яэл-Азым”*** гэж хэлнэ. ***“Сэми’аллаахү лимэн хамидэх”*** хэмээн рукүгээс өндийж, ***“Раббэна лэкэл хамд”*** гэж хэлсний дараа: ***“Аллаху Экбэр”*** хэмээн сэждэд очино.

Харин эмэгтэйчүүд; рукүд очихдоо эрэгтэйчүүдээс арай бага хэмжээнд бөхийж, өвдөгөө бага зэрэг нугалан хуруунуудаа салгалгүйгээр гараа өвдгөн дээрээ тавина.

СЭЖДЭ

13) Сэждэд 3 удаа ***“Сүбхаанэ Рабби-яэл-алаа”*** гэж хэлээд, ***“Аллаху Экбэр”*** хэмээн сэждэгээс өндийнө. Түр суугаад дахин ***“Аллаху Экбэр”*** хэмээн хоёрдахь сэждэг үйлдэнэ. Мөн гурван удаа ***“Сүбхаанэ Рабби-яэл-ала”*** гэж хэлээд, дараа нь ***“Аллаху Экбэр”*** хэмээн өндийн ***Тахияяатад*** **(сүүлчийн суултанд)** сууна.



Эмэгтэйчүүд сэждэд тохойгоо газарт хүргэн гэдэсээ өвдөгөндөө ойрхон байрлалтайгаар сэждэд очиж гурван удаа ***“Сүбхаанэ Рабби-яэл-алаа”*** гэж хэлнэ.

ТАХИЯЯАТ *СУУЛТ*

Сэждэгээс ***“Аллаху Экбэр”*** хэмээн өндийн сууна. Энэхүү суултыг *“Каадэ-и ахирияяэ”* (суулчийн суулт) гэж нэрлэнэ. Эрэгтэйчүүд зүүн хөлөө баруун тийшээ хэвтүүлэн тавьж баруун хөлийн хуруунууд киблэ рүү чиглэх байдлаар дарж сууна. Гараа чөөлөөтэй өвдгөн дээрээ тавина. Нүд энгэрээ ширтсэн байдалтайгаар ***“Эттэхияяатү”*** залбирлыг уншина.

Эмэгтэйчүүд хоёр хөлөө хоёуланг нь баруун тийш тавин зүүн хөлийн шагайг дарж сууна. Мөн гарын хуруунуудаа нийлүүлэн өвдгөн дээрээ тавина.

Эттэхияяаатү лиллаахи вэс-солэваатү вэ'т-тояяибаат. Эссэлаамү алэйкэ эюүхэ'н-нэбиюю вэ рахмэ-туллаахи вэ бэро-каатүх. Эссэлаамү алэйнаа вэ алаа ибаадил-лаахи'с-соолихийн. Эшхэдү энлаа илаахэ иллаллаах. Вэ эшхэдү эннэ Мухаммэдэн абдүхүү вэ Расуулүх.

Сүүлчийн суултанд *"Эттэхияяаатү"* залбирлыг уншсаны дараа *(Салли, Баарик болон Раббэна, раббэнагфирли)* залбирлуудыг уншина.

- Аллахүммэ солли алаа сэяяидинаа Мухаммэдин вэ алаа аали сэяяидинаа Мухаммэд. Кэмаа соллэйтэ алаа иброохиймэ вэ алаа аали иброохийм. Иннэкэ хамийдүм-мэжийд.

- Аллахүммэ баарик алаа сэяяидинаа Мухаммэдин вэ алаа аали сэяяидинаа Мухаммэд. Кэмаа баароктэ алаа иброохиймэ вэ алаа аали иброохийм. Иннэкэ хамийдүм-мэжийд.

- Раббэнаа аатинаа фи'д-дүняаа хасанэтэн вэ фил-аахирэти хасанэтэн вэ кынаа азаабэннаар. Бирахмэтика яаа Эрхамэр-Раахимийн.

Раббэнаг-фирлий вэ ливаалидэяяэ вэлил мү'минийнэ яэвмэ яэкуумү'л-хисааб.

15) Эдгээр залбирлуудыг уншиж дууссаны дараа: толгойгоо эхлээд баруун тийш эргүүлэн баруун мөр лүүгээ харж; ***"Эссэламү алэйкүм вэ рахмэтүллаах"*** гэж хэлнэ.

Толгойгоо мөн адил зүүн мөр рүүгээ харж ***“Эссэламу алэйкум вэ рахмэтуллаах”*** гэж хэлнэ.

Ийнхүү өглөөний мөргөлийн хоёр *рэкат суннэт* дуусна. *Фарзыг* суннэттэй адил хэлбэрээ уншина. Зөвхөн ниеэт өөрчлөгдөнө. Бүх мөргөлийн фарзыг уншиж дууссаны дараа Гэгээн Элчийн (с.а.с) зөвлөснөөр гурван удаа: ***“Эстагфируллахэл-азым”*** гэж хэлнэ. Утга нь: “Аяа Аллах Эзэн! Нүгэлүүдийг минь өршөөж хайрла.”

Мөргөлийн дараа унших залбирал болон тэсбихууд:

Аллаахуммэ энтэссэлааму вэ минкэссэлаам. Тэбаароктэ яаа зэлжэлаали вэл-икроом.

А’лаа расулинаа салаваат.

(Аллаахуммэ салли алаа сэяяидинаа Мухаммэдин вэ алаа аали сэяяидинаа Мухаммэд) хэмээн дотроо хэлнэ.

Сүбхааналлахи вэлхамдулиллаахи вэлаа илаахэ илаллаахү валлаахү экбэр. Вэлаа хавлэ вэлаа куввэтэ иллаа биллаахил алияяил-азийм.

Энэхүү залбирлын дараа *“Э’үзү- Бэсмэлэ”* -тэй цуг *“Аяэтэл- Күрси”*-г уншина. Дараа нь доорх тэсбих залбируудыг хэлнэ.

Тэсбихууд:

Субхааналлах: (33 удаа) – Аллахыг шагшин магтая.

Элхамдулиллаах: (33 удаа) – Аллахад талархая.

Аллаахүэкбэр: (33 удаа) – Аллах хамгийн Агуу нь.

Аллаахү-экбэр, лаа илаахэ ил-лаллаахү вахдэхү лаа шэрийкэ лэх. Лэхүл-мүлкү вэ лэхүл-хамдү вэ хүвэ алаа күлли шэй-ин кадийр.

Бүх Мөргөлийн Дараа Уншиж Болох Нэгэн Залбирал:

Э'үзү биллахи минэш-шэйтаанир-ражийм. Бисмиллаахир-рахмаанир-рахийм.

Талархал Ертөнцийн Эзэнд, амар мэнд Гэгээн Мухаммэд болон түүний гэр бүл, анд нөхдөд хүрэх болтугай. Бид зөвхөн Түүнд талархаж, Түүнээс л тусламж хүсч, өршөөл эрнэм. Эргэлзээгүй Тэрбээр өршөөлийг машид хүлээн авагч мөн нөгөө ертөнцөд мү'минчүүдийг машид өршөөгч билээ.

Аяа Рабб Эзэн минь! Үйлдсэн мөргөлүүдийг минь, ибадэтүүдийг минь, дутуу дулимагтай нь цуг хүлээн зөвшөөрч хайрла...

Аяа Рабб Эзэн минь! Нүгэлүүдийг минь өршөөж хайрла, биднийг энэрч хайрла, биднийг диваажиндаа багтааж, тамыг галаас хамгаалж хайрла.

Аяа Рабб Эзэн минь! Ислам шашин болон мусульманчуудад туслаж харла.

Аяа Рабб Эзэн минь! Хараал зүхэл, Ширк (Аллахтай өөр бусдыг эн зэрэгцүүлэх), ядуурал болон булшны тамлалаас хамгаалж хайрла.

Аяа Рабб Эзэн минь! Танаас урт удаан амьдрал, үр ашигтай эрдэм мэдлэг, энэ ертөнц болон нөгөө ертөнцөд амар амгалан байдлыг хүснэм.

(Энэ хооронд Аллахаас хүсэж буй зүйлсээ бүгдийг нь хэлнэ...)

Аяа Рабб Эзэн минь! Их шүүлтийн өдөр намайг, эцэг эхийг минь мөн бүхий л мусульманчуудыг энэрэлдээ багтааж хайрла, Аяа Энэрэнгүй, Нигүүлсэнгүй Аллах Эзэн Минь!

Амин! Амин! Аяа Рабб Эзэн минь залбирлуудыг минь хүлээн авагтүн.

Сүбхаанэ Раббикэ, Раббил-иззэти аммаа яэсифуун вэ сэлаамүн алэл мүрсэлийн, Вэлхамдү лиллаахи Раббил Аалэмийн. Эл-Фаатиха” гэж хэлээд хойноос нь Э’үзү-Бэсмэлэтэй цуг Фатиха бүлгийг уншина.

Их Үдийн Мөргөлийг Хэрхэн Үйлдэх Тухай

Их үдийн мөргөл нийт 10 рэкат. 4рэкат эхний сүннэт, 4рэкат фарз, 2рэкат сүүлчийн сүннэт.

Их Үдийн Мөргөлийн Эхний Сүннэт: 4 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө их үдийн мөргөлийн сүннэтийг үйлдэхээр” гэж хэлнэ. Өглөөний мөргөлийн сүннэттэй адил 2 рэкат уншсаныхаа дараа суугаад *“Эттэхияяаатү”* уншина. Дараа нь ямар нэг зүйл уншилгүйгээр *“Аллаху Экбэр”* хэмээн 3 дахь рэкатад босч зогсоно. 3 болон 4дахь рэкатыг Бэсмэлэгээр эхлэн Фатиха болон богино бүлэг уншиж өмнөх 2 рэкаттай ижил үйлдэж дуусаад сүүлчийн суултанд *“Эттэхияяатү, Аллахүмма салли, Аллахүмма баарик, Раббэна, Раббэнагфирли”* залбирлуудыг уншаад хоёр талдаа сэлам өгнө.

Их Үдийн Мөргөлийн Фарз: 4 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө их үдийн мөргөлийн фарзыг үйлдэхээр” гэж хэлнэ. Их үдийн мөргөлийн эхний сүннэттэй ижилхэн. Гэхдээ 3 болон 4дахь рэкатад зөвхөн *“Фатиха”* уншина. Өөр ямар нэг богино бүлэг болон ишлэл уншихгүй.

1. Рэкат:	2. Рэкат:	Түр суулт:
Камэт (Зөвхөн эрэгтэйчүүд)	*Бэсмэлэ*	*Эттэхияяаату*
Ниеэт	*Фатиха*	
Тэкбир	*Богино бүлэг эсвэл ишлэл*	
Субхаанэкэ	*Рукү*	
Э'үзү Бэсмэлэ	*Сэждэ*	
Богино бүлэг эсвэл ишлэл		
Рукү		
Сэждэ		

3. Рэкат:	4. Рэкат:	Сүүлчийн суулт:
Бэсмэлэ	*Бэсмэлэ*	*Эттэхияяаату*
Зөвхөн Фатиха уншина	*Фатиха уншина*	Аллахүммэ салли
Рукү	*Рукү*	Аллахүммэ баарик
Сэждэ	*Сэждэ*	Раббэна
		Раббэнагфирли
		Сэлам

Тэмдэглэл: Их үдийн мөргөл, бага үдийн мөргөл болон шөнийн мөргөлийн фарзууд бүгд адилхан уншигдана.

Их Үдийн Мөргөлийн Сүүлчийн Сүннэт: 2 рэкат: “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө их үдийн мөргөлийн сүүлчийн сүннэтийг үйлдэхээр” гэж хэлнэ.

Тэмдэглэл: Өглөөний мөргөлийн сүннэттэй ижилхэн үйлдэнэ. Оройны мөргөлийн сүннэт болон шөнийн мөргөлийн сүүлчийн 2 рэкат сүннэтийг ижилхэн үйлдэнэ.

БАГА ҮДИЙН МӨРГӨЛИЙГ ХЭРХЭН ҮЙЛДЭХ ТУХАЙ

Бага үдийн мөргөл нийт 8 рэкат. 4 рэкат сүннэт, 4 рэкат фарз.

Бага үдийн мөргөлийн сүннэт: Нийт 4рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө бага үдийн мөргөлийн сүннэтийг үйлдэхээр” хэмээн ниеэт хэлнэ. Их үдийн мөргөлийн эхний сүннэттэй ижилхэн үйлдэнэ. Гэхдээ хоёр дахь рэкатад *“Эттэхияяаатү”*-г уншсаныхаа дараа *“Аллахүммэ салли, Аллахүммэ баарик”* уншина. Түүний дараа *“Аллаху Экбэр”* хэмээн гурав дахь рэкатад босоод мөргөлөө эхнээс нь эхлэж байгаа мэт *“Сүбхаанэкэ, Э’үзү-бэсмэлэ”*-гийн дараа Фатиха болон богино бүлэг, ишлэл уншина.

Бага үдийн мөргөлийн фарз: Нийт 4 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө бага үдийн мөргөлийн фарзыг үйлдэхээр” хэмээн ниеэт хэлнэ. Их үдийн мөргөлийн Фарзтай ижилхэн үйлдэнэ.

Оройны Мөргөлийг Хэрхэн Үйлдэх Тухай

Оройны мөргөл нийт 5 рэкат. 3 рэкат фарз, 2 рэкат сүннэт.

Оройны мөргөлийн Фарз: 3 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө оройны мөргөлийн фарзыг үйлдэхээр” хэмээн ниеэт хэлнэ. Эхний хоёр рэкатыг өглөөний мөргөлийн фарзтай ижилхэн үйлдээд түр суугаад *“Эттэхияяаату”*-г уншина. Дахин гурав дахь рэкатад босоод фатихагийн дараа ямар нэг бүлэг ишлэл уншихгүй. Сүүлчийн суултанд “Эттэхияяаату, Салли баарик болон Раббэна, Раббэнагфирли”-г уншина.

Оройны мөргөлийн Сүннэт: 2 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө оройны мөргөлийн сүннэтийг үйлдэхээр” хэмээн ниеэт хэлнэ. Өглөөний мөргөлийн сүннэттэй ижилхэн үйлдэнэ.

Шөнийн Мөргөлийг Хэрхэн Үйлдэх Тухай

Шөнийн мөргөл нийт 10 рэкат. 4 рэкат эхний сүннэт, 4 рэкат фарз, 2 рэкат сүүлчийн сүннэт.

Шөнийн мөргөлийн эхний сүннэт: 4 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө шөнийн мөргөлийн эхний сүннэтийг үйлдэхээр” гэж ниеэт хэлнэ. Бага үдийн мөргөлийн сүннэттэй ижилхэн үйлдэнэ.

Шөнийн мөргөлийн фарз: 4 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө шөнийн

мөргөлийн фарзыг үйлдэхээр” гэж ниеэт хэлнэ. Бага үд болон их үдийн мөргөлийн фарзтай ижилхэн үйлдэнэ.

Шөнийн мөргөлийн сүүлчийн сүннэт: 2 рэкат. “Ниеэт хэлж байна, Аллах Эзэний таалалыг хүртэхийн төлөө шөнийн мөргөлийн сүүлчийн сүннэтийг үйлдэхээр” гэж ниеэт хэлнэ.

Тэмдэглэл: Өглөөний мөргөлийн сүннэттэй ижилхэн үйлдэнэ. Оройны мөргөлийн сүннэт болон их үдийн мөргөлийн сүүлчийн сүннэтүүдийг ижилхэн үйлдэнэ.

Витир Мөргөл

Витир мөргөл нийт 3 рэкат. Эхний хоёр рекатыг өглөөний мөргөлийн сүннэттэй ижилхэн. Гэхдээ хоёр дахь рэкатад суугаад зөвхөн “Эттэхияяаату”-г уншаад гурав дахь рэкэтад босно. Бэсмэлэ, фатиха болон богино бүлэг ишлэл уншаад гараа доош буулгаад дахин 2 чихний хэмжээнд өргөн тэкбир аваад дахин гараа холбож барина. Харин эмэгтэйчүүд 2 гараа мөрний хэмжээнд өргөж тэкбир авна. Дараа нь Кунут залбирлуудыг уншаад (залбирлийг хойноос харна уу.) Үүний дараа Руку, сэждэ үйлдэн сүүлчийн суултанд суугаад унших ёстой залбирлуудаа хэлээд дуусгана.

Кунут залбирлыг мэдэхгүй хүмүүс цээжлэх хүртлээ 3 удаа **“Аллахүммэгфирли”** хэмээн рукуд очиж болно.

3 Рэкат Витир Мөргөл Хэрхэн Үйлдэх Тухай

1.Рэкат:	2.Рэкат:	Түр суулт:
Ниеэт	Бэсмэлэ	Эттэхияяаату
Тэкбир	Фатиха	
Сүбхаанэкэ	Богино бүлэг эсвэл ишлэл	
Э'үзү бэсмэлэ	Рукү	
Фатиха	Сэждэ	
Богино бүлэг эсвэл ишлэл		
Рукү		
Сэждэ		

3.Рэкат:	Дундын тэкбир	Сүүлчийн суулт:
Бэсмэлэ	Дундын тэкбир + кунут залбирлууд	Эттэхияяааату
Фатиха	Рукү	Аллахүммэ салли
Богино бүлэг эсвэл ишлэл	Сэждэ	Аллахүммэ баарик
		Раббэна
		Раббэнагфирли
		Сэлам

Мөргөлийн *Фарзууд*

Энэхүү номны эхэнд *“32 фарз”*-д дурьдсан байгаа.

Мөргөлийг Хүчингүй болгох Зүйлс

1- Энэ ертөнцийн зүйлсийг бодон дуу гарган уйлах, өвчин аль эсвэл хэт их ядарснаас болж “Ёхлох” гинших.

2- Хүчээр ханиалгах.

3- Ямар нэг зүйл үлээх.

4- Хэн нэгэнд хариу өгөхийн тулд ямар нэг ишлэл унших.

5- Мэстийн (ус нэвтэрдэггүй арьсан оймс) дээр хийсэн мэсхийн хугацаа нь дуусах.

6- Мөргөлийн дундуур муур болон нохой хөөх зорилгоор “Жшшш” гэх мэт дуу авиа гаргах.

7- Мөргөл үйлдэх явцад аманд орсон цас,бороо, мөндрийн усыг залгих.

8- Ишлэлийг буруу уншиж, утгыг нь эвдэх.

9- Эрэгтэй эмэгтэй хүмүүс хорондоо ямар нэг хаалт тавихгүйгээр зэрэгцэн зогсож үйлдэх.

10- Мөргөлийн нэг рүкунд гурван удаа аль нэг газраа маажих.

11- Мөргөлийн нэг рукүн үйлдэх хэмжээний хугацаанд биеийн аврэт (далдлах ёстой) хэсэг ил гарах аль эсвэл хувцсанд нь мөргөл үйлдэхэд саад болохуйц бохир зүйл наалдах.

12- Сэждэд хоёр хөлөө нэгэн зэрэг өргөх.

13- Мөргөл үйлдэх үед сарын тэмдэг ирэх.

14- Өглөөний мөргөл үйлдэж байх үед нар мандах.

15- Мөргөлийн үед мартаад, санамсаргүй аль эсвэл санаатайгаар ярих.

16- Мөргөлийн үед ямар нэг зүйл идэх эсвэл залгих.

17- Өөртөө сонсогдохуйц инээх (Дэргэдэх хүндээ сонсогдохуйц инээх аваас абдэст угаалга мөн эвдэрнэ.)

18- Киблэгээс цээжээ эргүүлэх.

19- Мөргөл үйлдэх явцдаа ямар нэг ажил хийхийг оролдох.

Андуурсан, Алдаа Гаргасан Үед Хийх Сэждэ (Сэждэ-И Сэхв)

Сэждэ-и сэхв, андуурсан, алдаа гаргасан үед хийх сэждэ гэсэн үг. Санаатайгаар бус мартаад дутуу аль эсвэл санамсаргүйгээр илүү хийсэн алдааг залруулна.

Сэждэ-и сэхв-ийг дараах 3 тохиолдолд хийнэ:

1- Фарзыг оройтуулсан үед.

2- Важибыг орхигдуулсан үед.

3- Важибыг оройтуулсан үед.

Сэждэ-и сэхв-ийг дараах байдлаар хийнэ: Үйлдэж буй мөргөлийнхөө сүүлчийн суултанд, “Эттэхияяаату”

уншаад зөвхөн баруун талдаа сэлам өгөөд “Аллаху Экбэр хэмээн дахин хоёр удаа сэждэ хийгээд эхнээс нь “Эттахияяаатү, Аллахүммэ салли, Аллахүммэ баарик, Раббэна, Раббэнагфирли залбирлуудыг уншиж дуусаад хоёр талдаа сэлам өгнө. Ийнхүү мөргөлийнхөө дутуу хэсгийг гүйцээсэнд тооцогдоно.

Өглөөний Мөргөлийн Дараа Унших Бүлэг

هُوَ اللَّهُ الَّذِي لاَ إِلَهَ إِلاَّ
هُوَ عَالِمُ الْغَيْبِ وَالشَّهَادَةِ هُوَ الرَّحْمَنُ الرَّحِيمُ {٢٢}
هُوَ اللَّهُ الَّذِي لاَ إِلَهَ إِلاَّ هُوَ الْمَلِكُ الْقُدُّوسُ السَّلامُ الْمُؤْمِنُ
الْمُهَيْمِنُ الْعَزِيزُ الْجَبَّارُ الْمُتَكَبِّرُ سُبْحَانَ اللَّهِ عَمَّا يُشْرِكُونَ {٢٣}
هُوَ اللَّهُ الْخَالِقُ الْبَارِئُ الْمُصَوِّرُ لَهُ الأَسْمَاءُ الْحُسْنَى
يُسَبِّحُ لَهُ مَا فِي السَّمَاوَاتِ وَالأَرْضِ وَهُوَ الْعَزِيزُ الْحَكِيمُ {٢٤}

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Хүваллаахүллэзи лаа илаахэ иллаа хү.Аалимул-гайби вэ'ш-шэхаадэти хүвэ'р-Рахмаанү'р-Рахийм. Хүваллаахүллэзи лаа илаахэ иллаа хү. Эл-Мэликү'л-Куддуусү'с-Сэлаамул-Мү^минү'л-Мүхэйминү'л-Азийзү'л-Жэббаарү'л-мүтэкэббир. Сүбхааналлаахи аммаа юүширикүүн. Хүвэллаахү'л-Хааликү'л-Баари'үл-Мусаввиру Лэху'л Эсмаа'ул Хуснаа. Юүсэббихү лэхүү маа фи'с-сэмааваати вэ'л-ардь вэ хүвэ'л-Азийзү'л-Хакийм.

Шөнийн Мөргөлийн Дараа Унших Бүлэг

آمَنَ الرَّسُولُ بِمَا أُنزِلَ إِلَيْهِ مِن رَّبِّهِ وَالْمُؤْمِنُونَ كُلٌّ آمَنَ بِاللَّهِ
وَمَلآئِكَتِهِ وَكُتُبِهِ وَرُسُلِهِ لاَ نُفَرِّقُ بَيْنَ أَحَدٍ مِّن رُّسُلِهِ
وَقَالُواْ سَمِعْنَا وَأَطَعْنَا غُفْرَانَكَ رَبَّنَا وَإِلَيْكَ الْمَصِيرُ ﴿٢٨٥﴾
لاَ يُكَلِّفُ اللَّهُ نَفْساً إِلاَّ وُسْعَهَا لَهَا مَا كَسَبَتْ وَعَلَيْهَا مَا اكْتَسَبَتْ
رَبَّنَا لاَ تُؤَاخِذْنَا إِن نَّسِينَا أَوْ أَخْطَأْنَا رَبَّنَا وَلاَ تَحْمِلْ عَلَيْنَا
إِصْراً كَمَا حَمَلْتَهُ عَلَى الَّذِينَ مِن قَبْلِنَا رَبَّنَا وَلاَ تُحَمِّلْنَا
مَا لاَ طَاقَةَ لَنَا بِهِ وَاعْفُ عَنَّا وَاغْفِرْ لَنَا وَارْحَمْنَا أَنتَ
مَوْلاَنَا فَانصُرْنَا عَلَى الْقَوْمِ الْكَافِرِينَ ﴿٢٨٦﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Аамэнэррасуулү бимаа үнзилэ илэйхи мин Раббихий вэл мү'минуун. Күллүн аамэнэ биллаахи вэ мэлаа-икэтихий вэ күтүбихий вэ русулих. Лаа нуфэррику бэйнэ эхадин мин русулих. Вэ коолуу сэми'наа вэ ато'на гуфраанэкэ Раббэнаа вэ илэйкэ'л-масийр. Лаа юүкэллифуллахү нэфсэн иллаа вүс'ахаа, лэхаа маа кэсэбэт вэ алэйхаа мэктэсэбэт. Раббэнаа лаа тү'аахизнаа иннэсийнаа эв ахто'наа. Раббэнаа вэлаа тахмил алэйнаа исрон кэмаа хамэлтэху алэллэзийнэ мин кавлинаа. Раббэнаа вэ лаа

тухаммилнаа маа лаа тоокота лэнаа бих, ваа'фу аннаа вагфир лэнаа вэрхамнаа энтэ Мэвлаанаа фэ'н-сурнаа алаал-кавмил-каафирийн.

Олон нийтээрээ мөргөл үйлдэхийн ач холбогдол: Олон нийтээрээ мөргөл үйлдэхийн ач буян нь, ганцаараа үйлдсэн мөргөлөөс хорин тав, өөр нэгэн дам яриагаар бол хорин долоо дахин их байдаг. Жич: Хоёр болон түүнээс дээш хүн олон нийтэд тооцогдоно.

Өдөр Тутмын Таван Мөргөлөөс Гадуурх Бусад Мөргөлүүд

Жума буюу тавдахь өдрийн Их Мөргөл: Хугацаа нь: Их үдийн мөргөлийн цаг юм. Их үдийн мөргөлийн оронд олон нийтээрээ хоёр рэкэт үйлдэнэ. Нийт 10 рэкат.

Дөрвөн рэкат нь фарзаас өмнө, харин дөрөв нь фарзын дараа нийт найман рэкат сүннэт үйлдэнэ. Мөргөлийн цаг орсны дараа дөрвөн рэкат сүннэтийг үйлдэнэ. Хутбэ уншиж дууссаны дараа олон нийттэй цуг хоёр рэкат жума мөргөлийг үйлдэнэ. Үүний дараа дахин дөрвөн рэкат сүннэт үйлдэнэ.

Дараа нь “Тухайн цагийн сүннэт” хэмээх ниеэтээр хоёр рэкат сүннэт мөргөл үйлдэх нь илүү зохимжтойд тооцогдоно.

Жума Мөргөл Фарз Болох Болзлууд:

1- Эрэгтэй байх, (Жума мөргөл нь эмэгтэйчүүдэд фарз биш юм. Гэхдээ жума мөргөлд оролцож имамтай цуг унших аваас их үдийн мөргөлөө үйлдсэнд тооцогдоно.)

2- Жума мөргөлд явахын тулд эрх чөлөөтэй байх

3- Аян замд гараагүй байх (суурин байх)

4- Ямар нэг өвчингүй эрүүл саруул байх

5- (Сохор) Харааны бэрхшээлгүй байх

6- Мөргөлд явахад ямар нэг саад бэрхшээл байхгүй байх.

Жума Мөргөл Хүчин Төгөлдөр Болох Нөхцөл Шаардлагууд:

Жума мөргөлийн фарз болоход зарим нэг шаардлагууд байдгийн адил, хүчин төгөлдөр болоход нөлөөлөх зарим нэг нөхцөл шаардлагууд гэж бий:

1- Жума мөргөлийг их үдийн мөргөлийн цагт үйлдэх,

2- Мөргөлийн өмнө хутбэ унших,

3- Мөргөл үйлдэж буй газар хүн бүрт нээлттэй байх,

4- Имамаас гадна хамгийн багадаа гурван эрэгтэй хүн байх, (Имам Эбү Юусуфийн үзлээр бол 2 эрэгтэй хүн байхад хүчин төгөлдөрт тооцдог байна.)

5- Их мөргөл үйлдүүлэхээр томилогдсон хэн нэгэн байх,

6- Их мөргөл үйлдэх газар, хот аль эсвэл хотод тооцогдохуйц газар байх.

Баярын Мөргөлүүд

Жума мөргөл фарз болох хүмүүс жилдээ хоёр удаа баярын мөргөл үйлдэх ёстой.

Баярын мөргөл нь хоёр рэкат байдаг. Мөн олон нийттэй цуг үйлдэнэ. Нар мандаснаас хойш 45-50 минутын дараа баярын мөргөлийн цаг орно. Мөргөлийн цаг орсны дараа олон нийт эгнээ үүсгэн зогсож, “Ниеэт хэлж байна важиб болох баярын мөргөлийг үйлдэхээр, имамыг дагахаар.” хэмээн ниеэт хэлнэ.

Гийчин *(аян замын)* Мөргөл

Дунд зэргийн хурдтайгаар гурван өдөр (90 км). Аль нэг тийш явахын тулд ниеэт гарган оршин буй газраасаа гарсан хүн гийчин (аян замын) хүнд тооцогдоно.

Тухайн газартаа 15 өдрөөс бага хугацаанд байхаар ниеэт гаргасан бол аян замын хүнд тооцогдоно. Харин очсон газртаа 15 болон түүнээс дээш хугацаанд байхаар ниеэт гаргасан бол аян замын хүнд тооцогдохгүй. Өнөөдөр явна, маргааш явна гэсээр, 10 жил болсон ч гэсэн аян замын хүнд тооцогдсон хэвээр байх болно.

Гийчин хүн 4 рэкат фарзыг 2 рэкат болгон уншина. Гурав болон хоёр рэкатуудыг бүтэн уншина. Аян замд болон буудалласан газарт хэсэг (урт) хугацаанд амрахаар бол сүннэтүүдийг уншина.

Исламд Орох Хаалга:

“Кэлимэ-и Тэвхид болон Кэлимэ-и Шэхадэт”

Хэрхэн мусульман болох вэ?

Кэлимэ-и тэвхид болон Шэхаадэтийг хэлж мөн сэтгэл зүрхнээсээ итгэж байж мусульман болно.

Ислам шашины үндэс нь юу вэ?

Кэлимэ-и тэвхид.

Кэлимэ-и Тэвхид:

“Лаа илаахэ илаллах, Мухаммэдүн Расуулуллах”

Утга нь: “Цор ганц Аллахаас өөр Эзэн үгүй, Гэгээн Мухаммэд (с.а.с) Түүний ариун Элч юм.”

Аллах Эзэнийг бурхан, шүтээн гэж хэлж болохгүй: Аллах хэмээх нэрээр, Аллахаас өөр ямар ч зүйлийг бурхан, шүтээн хэмээн нэрлэж болохгүй. Мөн Аллах хэмээх нэрийг бурхан, шүтээн хэмээн орчуулж болохгүй.

Лаа илаахэ (Тэрээр цор ганц): Өөрсдийгөө өргөмжлөн шүтэгсдийг хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ мөн

зүрх сэтгэлээ эдгээрээс ангижруулан цэвэрлэнэ хэмээн Аллахад тангараглаж байна. Би эдгээр шүтээнүүдээс ангижруулсан зүрх сэтгэлээ, зөвхөн Аллахад болон түүний шашинд бэлдэнэ. Учир нь бохир зүрх сэтгэлд, цэвэр ариун Аллахын итгэл үнэмшил үл сууна. Өмхөрсөн суурин дээр бат бөх барилга баригдахгүйтэй адил.

Иллаллаах: Мухар сүсэгүүдийг үгүйсгэснийхээ дараа зөвхөн Аллахыг хүлээн зөвшөөрч байна.

Мухаммэдүн Расуулуллах: “Рабб Эзэний төлөө үйлдэх ибадэтүүдээ бид'атуудын (сүүлд шашинд нэмэгдсэн зохиомол зүйлс) дагуу бус, Аллахын Куран Кэримд харуулсан, Гэгээн Элчийн зааж, бидэнд харуулсан байдлаар хийнэ гэдгээ Аллахад тангараглаж байна...” гэсэн үг юм.

Кэлимэ-и Шахадэт:

“Эшхэдү эн лаа илаахэ иллаллаах вэ эшхэдү эннэ Мухаммэдэн абдүхү вэ Расуулүхү.”

Утга нь: Би өөрийн биеэр гэрчлэе Аллахаас өөр эзэн үгүй. Дахин би өөрийн биеэр гэрчлэе Мухаммэд (с.а.с) Түүний боол буюу элч юм.

Эшхэдү эн лаа илаахэ иллаллаах: “Би бодоод, ухаараад, зүрх сэтгэлдээ хүлээн зөвшөөрөөд үүнийгээ хэлээрээ хэлж байна; Аллахаас өөр Эзэн, нэг үгээр хэлбэл хүч, эцэс төгсгөлгүй эрх мэдэл, өөрөөр хэлбэл орчлон ертөнц дахь хүмүүсийн төлөө хорио тавьж мөн өөртөө албат болгох өөр нэгэн үгүй” хэмээх үг юм.

АЛЛАХАД ИТГЭХ ИТГЭЛ

ӨГҮҮЛЛЭГ: Аллах Бид Бүхнийг Харж Байдаг:

Саалих өвөөгөөсөө:

- Бид нар Аллахыг яагаад харахгүй байгаа юм бэ? хэмээн асуужээ.

Өвөө нь:

- Бид нарын нүд Аллахыг харах байдлаар бүтээгдээгүй учраас бид түүнийг харж чадахгүй, хэмээн хариулжээ.

- Ийм зүйл байж болон гэж үү өвөө?

- Чи зургийн аппаратаар бүх зүйлсийн зургийг авч чадах уу?

- Тийм, авч чадна.

- Хүний уушиг, ходоодны зургийг авч чадах уу?

- Үгүй, тэдний зургийг рентген аппарат л авч чадна.

- Тэгвэл энэ хоёр аппарат хоёулаа зураг авч чаддаг хирнээ, рентген аппаратны тусламжтайгаар гарах зургийг зургийн аппарат авч чадахгүй. Учир нь тэдний хийц нь ялгаатай. Аллах, бидний нүдийг мөн адил өөрийг нь харах байдлаар бүтээгээгүй юм.

- Тэр биднийг харж чадах уу?

- Тийм ээ, түнэр харанхуй шөнө ч гэсэн биднийг харж байдаг.

Аллахын Шинж Чанарууд:

А- Заати Шинж Чанарууд, Б-Субути Шинж Чанарууд

А- *Заати Шинж Чанарууд:*

1- *Вужүд:* Оршин байх гэсэн үг. Аллах, хаа сайгүй хэдийд ч оршин байдаг.

2- *Кидэм:* Оршин буйн эхлэл гэж үгүй. Аллахын эхлэл гэж үгүй, үүрдийнх юм. Тэрээр төрөөгүй юм.

3- *Бэка:* Оршин буйн төгсгөл гэж үгүй. Аллахын төгсгөл гэж үгүй, үүрдийнх юм. Түүнд үхэл гэж үгүй.

4- *Вахданиеэт:* Цор ганц гэсэн үг. Өөрөөр хэлбэл Түүний шинж чанар болон үйлдлийг өөр ямар нэг зүйлээс олон гэдэг нь боломжгүй зүйл юм. Аллахын ижил төстэй зүйл гэж үгүй.

5- *Мухалэфэтүн лил хавадис:* Сүүлд бүтээсэн зүйлстэй ижил төсгүй гэсэн үг. Аллах сүүлд бүтээсэн ямарч зүйлтэй ижил төсгүй.

6- *Кияам би Нэфсихи:* (Кияам би Заатихи): Тэрбээр мөнхөд өөрөөрөө оршин тогтногч билээ. Аллах Эзэний оршин буй нь өөр ямар ч зүйлд хамааралгүй. Бүх зүйлс түүнд хамааралтайгаар оршин тогтоно.

Б- *Субути Шинж Чанарууд:*

1- *Хаяат:* Амьд гэсэн үг. Аллах, амьдрал бүтээгч юм.

2- *Илим:* Мэдэх гэсэн үг. Аллах, бүхнийг мэднэ.

3- *Сэми:* Сонсох гэсэн үг. Аллах, бүхнийг сонсоно.

4- *Басар:* Харах гэсэн үг. Аллах, бүхнийг харна.

5- *Ирадэ:* Хүсэх гэсэн үг. Бүх зүйл Аллахын хүсэл дор.

6- *Кудрэт:* Аллах Эзэн хүч чадлын Эзэн юм. Аллахын хүч чадал бүхий л зүйлд хүрнэ.

7- *Кэлам:* Ярих шинж чанар. Мөн Куран Кэрим нь Аллахын үг яриа юм.

8- *Тэквин:* Бий болгох, бүтээх гэсэн үг. Газар дэлхий болон тэнгэр огторгуй дахь бүхнийг Аллах бүтээсэн юм.

Аллахын Шинж Чанаруудтай Холбоотой Асуултууд

Чамайг хэн бүтээсэн бэ?	....
Бүхнийг харагч хэн бэ?	....
Бүхнийг сонсогч хэн бэ?	....
Бүхнийг мэдэгч хэн бэ?	....
Бүхий л зүйлд буян хишгийг хүртээгч хэн бэ?	....
Бүх зүйлсэд хүч чадал нь хүрэгч хэн бэ?	....
Хаа сайгүй оршин байгч хэн бэ?	....
Оршин буйн эхлэлгүй нь хэн бэ?	....
Оршин буйн төгсгөлгүй нь хэн бэ?	....
Ижил төсгүй нь хэн бэ?	....
Эн зэрэгцүүлэмгүй нь хэн бэ?	....
Алив хэн нэгнээс хамааралгүй нь хэн бэ?	....
Үхэшгүй мөнх оршигч нь хэн бэ?	....
Эцэс төгсгөлгүй хүч чадлын эзэн хэн бэ?	....
Төрөөгүй, төрүүлээгүй нь хэн бэ?	....
Биднийг хамгаалагч хэн бэ?	....
Биднийг уучилж өршөөгч хэн бэ?	....
Бидэнд амьдрал хайрлагч хэн бэ?	....
Рабб Эзэн чинь хэн бэ?	....
Хамгийн агуу нь хэн бэ?	....
Хамгийн хайртай зүйл маань юу бэ?	....
Хүнд хэцүү үед тусламж хүсэгч маань хэн бэ?	....
Айж сандрахдаа бид хэнд хорогддог бэ?	....
Бидэнд буян хишиг хайрлагч хэн бэ?	....
Биднийг гай гамшгаас хамгаалагч хэн бэ?	....

Бүхнийг бүтээгч нь АЛЛАХ юм

Дэлхий ертөнцийг бүтээгч хэн бэ?	....
Оддын бүтээгч хэн бэ?	....
Сарыг бүтээгч хэн бэ?	....
Нарыг бүтээгч хэн бэ?	....
Газар, тэнгэр, агаар мандлыг бүтээгч нь хэн бэ?	....
Үй түмэн оддыг тэнгэр огторгуйд тоогтоогч нь хэн бэ?	....
Бороо оруулагч хэн бэ?	....
Оргүй хоосноос хүн төрлөхтөнг бүтээгч хэн бэ?	....
Биднийг бүтээгч хэн бэ?	....
Эцэг эхийг маань бүтээгч хэн бэ?	....
Ан амьтдыг бүтээгч хэн бэ?	....
Өвс ургамлыг бүтээгч хэн бэ?	....
Уулсыг бүтээгч хэн бэ?	....
Жимс ногоог бүтээгч хэн бэ?	....
Бидэнд буян хишиг хүртээгч хэн бэ?	....
Амьгүй шорооноос амьд ургамал бүтээгч хэн бэ?	....
Ижилхэн үндэснээс ялгаатай цэцэгс болон үнэрийг бүтээгч хэн бэ?	....
Амьд биесийг үхүүлэгч хэн бэ?	....
Бүхнийг бүтээгч нь хэн бэ?	....
Бүхий л ертөнцийн эзэн нь хэн бэ?	....

Аллахын өмнө хүлээх бидний үүрэгүүд:

1- Зөвхөн Аллахад итгэх, Түүнээс өөр бусдыг шүтэхгүй байх.

2- Аллахыг чин сэтгэлээсээ, бүхнээс илүү хайрлах.

3- Нүгэлүүдээсээ зөвхөн Түүнд хорогдох

4- Зөвхөн Аллахад найдаж, Зөвхөн түүнээс тусламж хүсэх.

5- Ганцаараа мөн үргэлж Түүнд ибадэт үйлдэх.

6- Өгсөн буян хишгийнх нь хариуд, Түүнд талархах.

7- Дуртай зүйст нь дурлаж, дургүй зүйлсээс нь татгалзах.

8- Хий гэсэн зүйлсийг нь хийж хориглосон зүйлсийг нь хийхгүй байх.

Өгүүллэг: Аллахын оршин буйг үгүйсгэгч эрдэмтэн болон Имам-и Азам Эбу Ханифэгийн хариулт:

Нэгэн цаг үед Багдадад суут эрдэмтэн амьдардаг байжээ. Түүний нэр нь Имам-и Азам Эбү Ханифэ юм. Тэрээр дэлхий даяар танигдсан алдартай эрдэмтэн юмсанж. Маш олон оюутан бэлтгэн гаргажээ. Эргэн тойрныхон нь түүнийг ихэд хүндэлдэг байв.

Мөн тэр цаг үед өөрийгөө эрдэмтэн хэмээх нэгэн “Аллах байхгүй” хэмээн өөрийнхөөрөө зүтгэн, очсон газар бүртээ эрдэмтэдтэй маргалддаг байв. Энэ эр Эбү Ханифэгийн алдрыг сонссон аж. Өөрийгөө түүнтэй харьцуулахын хүсэн Багдадыг зорьжээ. Ингээд Эбү Ханифэг олж “Аллах бий юу? үгүй юу?” хэмээн маргалдахад Эбу Ханифэ түүнд тэр дор нь хариу өгсөнгүй. Маргааш нь тодорхой цагт энэ газраа уулзаж тэр үед хариу өгье хэмээжээ. Багдадын

төв хэсэгт Дижлэ хэмээх мөрөн урсаж хотыг яг дундуур нь хоёр хуваадаг аж. Маргааш нь Эбү Ханифэ, тохирсон цагаасаа хоцров. Өөрийгөө эрдэмтэн хэмээн өргөмжлөх эр хүлээсээр ихэд цухалджээ. Хүлээж ядан буцахын алдад Эбү Ханифэ хүрч ирэв: Өнөөх эр

- Яагаад оройтов? Үгүй бол надтай мэтгэлзэхээсээ айгаа юу? гэхэд Эбү Ханифэ инээмсэглэн:

- “Үгүй, би айгаагүй. Мэдэж байгаа биз дээ би голын нөгөө талд амьдардаг юм. Тэр талаас энэ тал руу гарахын тулд ойр хавьд гүүр байдаггүй. Хурдан гэгч нь дархан болон мэргэжилтэнгүйгээр гүүр өөрөө бий болог хэмээн хүссэн юм. Гэтэл гүүр өөрөө өөрөө баригдсан л даа; гэхдээ жаахан хугацаа орсон ч ямартай ч би амжаад ирлээ” гэжээ.

Өнөөх эр:

- Чи худлаа хэлж байна. Дархангүйгээр гүүр бий болон гэж юу байхав? Үүнд чинь итгэсэн хүн тэнэг хүн болон биз? гэв.

Эбү Ханифэ:

- Ээе хүн гуай! Өчүүхэн нэгэн гүүр өөрөө өөрөө бүтэх боломжгүй атал, энэ ертөнц хэрхэн бүтээгч эзэнгүй өөрөө өөрөө бий болон гэж үү? Энэ ертөнц битгий хэл, нэг навч хүртэл өөрийн дураар үл хөдлөнө. Чи одоо хүртэл бүх зүйл нэгэн шалтгаантай болохыг ойлгохгүй байна гэж үү?

Энэ үгсийн хариуд өөрийгөө эрдэмтэн хэмээх заргач,

алдаагаа ухаарч энэ ертөнцийг бүтээгч нэгэн бий гэдгийг сая ойлгон уучлалт гуйн заргаасаа буцан Аллахад итгэсэн гэдэг.

МЭЛЭК БУЮУ САХИУСАН ТЭНГЭРҮҮДЭД ИТГЭХ ИТГЭЛ

Сахиусан тэнгэрүүдийн онцлогууд:

а) Мэлэкүүд нь, гэрэлнээс бүтээгдсэн, нүгэлгүй цэвэр ариухан бүтээл юм. Тэдэнд эр,эм хүйсийн ялгаа гэж үгүй, гэрлэх, идэж уух, амрах гэх мэт хэрэгцээ байдаггүй.

б) Сахиусан тэнгэрүүд нүдэнд үл үзэгдэнэ.

в) Сахиусан тэнгэрүүд далд зүйлсийн талаар мэдэхгүй. Аллах Эзэн тэдэнд ямар нэгэн зүйл мэдэгдэх аваас зөвхөн түүнийг л мэднэ.

Сахиусан тэнгэрүүдийн үүрэгүүд:

Сахиусан тэнгэрүүдийн үүрэг нь, Аллахад талархаж түүнийг магтан дуулах мөн зарлиг болгосон зүйлсийг зүй ёсоор нь биелүүлэх явдал юм.

Дөрвөн том сахиусан тэнгэрийн үүрэг:

1- Жэбрайл: Элч нарт вахи (Аллах Эзэний зарлиг, тушаал) буюу судар авч ирэгч.

2- Микайл: Байгалийн үзэгдлийг хариуцна. (Бороо, салхи гэх мэт.)

3- Исрафил: Ертөнцийн төгсгөлийн өдөр болоход Сура үлээгч.

4- Азрайл: Амь авах үүрэгтэй сахиусан тэнгэр.

Эдгээр сахиусан тэнгэрүүд нь хамгийн том нь юм. Аллахын сахиусан тэнгэрүүдэд өгөх үүрэг эдгээр сахиусан тэнгэрүүдээр дамжиж бусад сахиусан тэнгэрүүдэд очно.

Өөр бусад сахиусан тэнгэрүүд болон тэдний үүрэгүүд:

Кирамэн-Катибин: Хүн бүрийн баруун болон зүүн талд байж хэлсэн, хийсэн бүхнийг нь тэмдэглэж авдаг сахиусан тэнгэрүүд юм. Баруун талд байрлах нь сайн үйлийг; зүүн талд байрлах нь муу үйлийг нь бичнэ. Ийнхүү бичигдсэн дэвтрүүдийг ертөнцийн төгсгөлийн өдөр эздэд нь өгөх болно. Их шүүлт энэхүү дэвтрийн дагуу явагдах болно.

Мүнкэр-Нэхир: Булшинд орсон хүнээс асуулт асуух үүрэгтэй сахиусан тэнгэрүүд юм.

Өгүүллэг: Азрайл, мянга мянган хүмүүсийн амийг хэрхэн нэгэн дор зэрэг авч чаддаг юм бол?

Бяцхан дүү нар минь! Та нар ч бас үүний талаар сонирхож байгаа биз дээ? Бидний сүнсийг асаж буй чийдэнтэй, харин үхлийг тог тасрахтай адилтгаж болох юм. Бидний гэрт цахилгаан түгээж буй утас цахилгааны төв системтэй холбоотой байдаг тийм биз дээ? Төв системийн инженер, доод ажилчиндаа: “Тэр дүүргийн цахилгааныг тасал!” гэж хэлэхэд, юу болохыг мэдэж байгаа биз дээ? Тэрхүү ажилтан тухайн дүүргийн цахилгааны нэгдсэн шонг буулгах үед ганцхан хормын дотор хэдэн мянган айлын чийдэн унтрах болно.

Тэгвэл бидний сүнс үл үзэгдэх утсаар Азрайлын өмнөх товчлууруудад холбоотой байна гээд бодоод үзье л дээ.

Тэгвэл Азрайлын ганц л үйлдлээр мянга мянган сүнс энэ хорвоогоос халин одох нь энгийн үзэгдэл юм.

СУДАРУУДАД ИТГЭХ ИТГЭЛ

Аллах Эзэний зүгээс илгээгдсэн тэнгэрлэг судрууд, гэгээн элч нарт вахи замаар дамжин ирсэн байдаг.

Вахи гэдэг нь: Аллах Эзэний, хүн төрлөхтний дундаас элч болгон сонгосон албатууддаа сахиусан тэнгэр Жэбрайлаар дамжуулан хүссэн зүйлээ мэдэгдэхийг хэлнэ. Вахи зөвхөн гэгээн элч нарт ирнэ. Аллах Эзэний зүгээс илгээгдсэн судруудын нэг хэсгийг нь хуудас гэж нэрлэдэг. Хэд хэдэн хуудас нь жижигхэн судар тооцогдоно. Тухайлбал:

Гэгээн Адэмд 10 хуудас

Гэгээн Шийтэд 50 хуудас

Гэгээн Идрист 30 хуудас

Гэгээн Ибрахиймд 10 хуудас илгээгдсэн байдаг.

Эдгээр хуудсууд олон зуун жилийн өмнө устаж үгүй болсон байдаг.

Дөрвөн том судар:

1. Тэврат: Гэгээн Муса-д илгээгдсэн.

2. Зэбур: Гэгээн Давут-д илгээгдсэн.

3. Инжил: Гэгээн Иса-д илгээгдсэн.

4. Куран Кэрим: Аллах Эзэний зүгээс Жэбрайлаар дамжин Гэгээн Элч Мухаммэд-д илгээгдсэн. Аллахын зүгээс ирсэн хэлбэрээ хадгалж ирсэн цор ганц судар нь Куран Кэрим юм.

Өнөөдрийн мусульманчуудын хийж байгаа шиг Куран нь, зөвхөн нас барсан хүмүүсийн төлөө уншигдахын тулд ирээгүй. Утга болон хууль дүрмийг нь ойлголгүйгээр өвчтэй хүмүүс болон оршуулгийн газарт очиж уншихын төлөө илгээгдээгүй юм. Куран Кэрим нь, мусульманчуудын төрсөн цагаасаа эхлэн үхэх хүртэлх бүхий л амьдралыг хамааруулсан хууль дүрмүүдийг багтаасан байдаг.

Мусульман хүн нь; гэр бүл, болон нийгмийн амьдралаа Кураны хууль дүрмийн дагуу зохицуулж түүнийг зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай юм.

Куран Кэрим 23 жилийн дотор бүтэн хэлбэрээрээ ирж дууссан юм. Нийт 114 ишлэл бий.

ГЭГЭЭН ЭЛЧ НАРТ ИТГЭХ ИТГЭЛ

Гэгээн Элч гэдэг нь: Аллах Эзэний албатууддаа хүссэн бүхнээ мэдэгдэхийн тулд сонгон, үүрэг хүлээлгэсэн хүмүүсийг хэлнэ.

Гэгээн Элч нарт байх ёстой шинж чанарууд:

1. ***Сидк:*** Шулуун шударга гэсэн үг. Гэгээн Элч нар маш зөв, шударга хүмүүс юм.

2. ***Эманэт:*** Гэгээн Элч нар, бүх талаараа найдвартай, итгэл даасан хүмүүс юм.

3. ***Тэблиг:*** Гэгээн Элч нар, Аллах Эзэний илгээсэн шашин болон шашины хуулийг тэр янзаар нь хүмүүст хүргэдэг.

4. ***Фэтанэт:*** Гэгээн Элч нар маш ухаантай, оюуны өндөр чадвартай байх ёстой юм.

5. *Исмэт:* Гэгээн Элч нар нүгэл болон муу муухай үйлээс ангид юм.

Гэгээн Элч нарын тоо:

Анхны элч Гэгээн Адам, харин сүүлчийн элч Гэгээн Мухаммэд юм. Энэ хоёрын хооронд маш олон элч нар ирсэн байдаг. Эдгээр элч нар бүгдээрээ хүн төрлөхтөнг цор ганц Аллахад итгэх итгэл (тэвхид итгэл) болон Аллахад албат байхад уриалан дуудсан байдаг. Хүн төрлөхтөн төөрөгдөлд орж, Аллахаас өөр бусдад мөргөж эхлэхэд, хүмүүсийг цор ганц болох Аллахад итгэхийг уриалан дуудах нэгэн шинэ элч илгээсэн байдаг.

***Куран Кэримд* нэр нь дурьдагдсан Гэгээн Элчүүд:**

Нийт 25 элчийн нэрс дурьдагдсан байдаг:

Адам	Ибрахим	Мууса	Юунус
Идрийс	Исмайл	Хаарун	Иляас
Нуух	Исхаак	Давуд	Элеэса
Хууд	Яакуп	Сулэйман	Зэкэрияяа
Саалих	Юусуф	Эээуб	Яахяа
Луут	Шуаяб	Зулкифл	Иса
Гэгээн Мухаммэд Мустафа (с.а.с)			

Ер бусын гайхамшиг: Гэгээн Элчийн зүгээс Аллахын зөвшөөрөл болон тусламжийн дагуу, элч болохыг нь гэрчлэн харуулахын тулд үзүүлэх ер бусын гайхамшигт

үзүүлбэрүүдийг ийнхүү нэрлэдэг юм. Жирийн хүн үүнийг хийж харуулан гэдэг нь боломжгүй зүйл юм.

Ертөнцийн Төгсгөлийн Өдөрт Итгэх Итгэл

Ертөнцийн төгсгөлийн өдөр: Бидэнд мэдэгдсэнээр: сахиусан тэнгэр Исраафилын үлээх “Сур” (бүрээний) дуугаар амьд бүхэн үхэх болно. Энэ үеэс эхлэн хүмүүсийн дахин амилах хийгээд диваажинд очих нь диваажинд, тамд очих нь тамд орох хүртэлх хугацааг “ертөнцийн төгсгөлийн өдөр” гэнэ. Өөр олон янзаар нэрлэсэн байдаг. Эдгээрийн дотроос хамгийн түгээмэл нь “нөгөө ертөнцийн амьдрал” юм.

Өөр нэг яриагаар бол: хүмүүсийн шүүгдэхээр дахин амилах өдрөөс эхлэн үүрд үргэлжлэх цаг хугацааг ертөнцийн төгсгөл гэж үзсэн байдаг.

Булшны амьдрал: Хүн нас барснаас эхлээд Аллахын өмнө шүүгдэхээр дахин амилах хүртэлх хугацааг булшны амьдрал гэж нэрлэдэг. Хүн булшинд орсны дараа хоёр сахиусан тэнгэр ирж: “Эзэн чинь хэн бэ? Элч чинь хэн бэ? Шашин чинь юу бэ?” хэмээх асуултуудыг асууна. Үүнийг булшны асуулт гэж нэрлэдэг. Эдгээр асуултууд нь нас барсан хүн бүрээс асуугдах болно. Шатсан, тарж бутарсан гээд л ямар ч янзаар үрэгдсэн нь хамаагүй энэхүү асуултаар заавал асуугдах болно.

Булшны амьдрал нь, нөгөө ертөнцийн амьдралын эхлэл гэсэн үг юм. Диваажинд очих хэн нэгэн булшинд байхдаа Диваажингийн амьдралын амтыг, мөн Тамд очих

хэн нэгэн тамын шийтгэлийг их-бага хэмжээгээр амсаж эхэлдэг байна.

Булшны амьдралыг энэ ертөнцийн амьдралтай зүйрлэн үзэхгүй байх хэрэгтэй.

Гэхдээ, бага үхэл хэмээн нэрлэгдэх зүүдэндээ бид баяр баясал, аймшигт өвдөлтийг сүнсээрээ мэдэрдэг учраас нөгөө ертөнцийн амьдралын жишээг энэ ертөнцөд мэдэрч байгаа гэсэн үг юм.

Диваажин: Мусульманчуудын төлөө бэлдсэн шагналын орон юм. Нэгэн ишлэлд; "Та нарын төлөө тэнд, хүссэн бүхэн хийгээд санасан бүхий л буян хишиг чинь байх болно." хэмээн айлджээ.

Там: Аллах Эзэнийг эсэргүүцэн боссоныхоо шийтгэлийг хүртэх газар юм. Тэнд, үл итгэгч, хоёр нүүртэн болж нас барагсад, нүгэл нь сайн үйлээсээ давагсад болон Аллахын энэрэлд багтаагүй муминчууд очих болно. Гэхдээ тэнд очсон муминчууд тодорхой хугацаанд шийтгэлээ хүртсэнийхээ дараа гарах болно. Үл итгэгчид, хоёр нүүртэнгүүд болон Аллахтай өөр бусдыг эн зэрэгцүүлэгсэд үүрд тэндээ үлдэх болно.

Махшэр: Исрафийл бүрээ үлээснээр бүх хүн төрлөхтөн, амьд бүхэн үхэх болно. Аллахаас өөр ямарч амьд амьтан үлдэхгүй. Хэсэг хугацаа ийм байдалтайгаар үргэлжлэх болно. Дараа нь Аллах Эзэн Исрафийлийг дахин амилуулж, бүрээ үлээлгэхэд хүмүүс дахин амилж шүүгдэхийн тулд Махшэр хэмээх газар цугларах болно.

Үйлийн дэвтэр: Махшэрт хүмүүсийн үйлийн дэвтэр (дэлхий ертөнцөд байхад нь сахиусан тэнгэрүүдийн бичиж бэлтгэсэн дэвтэр) тараагдах болно. Энэхүү дэвтэр диваажинд орох хүмүүст баруун талаас нь, Тамд орох хүмүүст зүүн талаас нь өгөгдөх болно.

Их шүүлт: Аллах Эзэн бүх хүмүүсийг нэгэн зэрэг шүүх болно. Гэхдээ хүн бүр зөвхөн өөрийг нь шүүсэн хэмээн ойлгох болно. Энэхүү шүүлтэд Гэгээн Элчийн айлдсан шиг:

1- Амьдралаа ямар замд үрсэн,

2- Мэддэг зүйлээрээ юу бүтээсэн,

3- Эд хөрөнгөө хаанаас олж, хаана зарцуулсан,

4- Бие махбодоо аль замд (Аллахын таалалд тохирох, эс тохирох замд) зориулсан тухай асуух болно. Эдгээр асуултуудад заавал хариулт авах болно.

Мизан (Жинлүүр): Хүний үйлдсэн сайн, муу үйлийг хэмжих болно. Хэн ч үл хохирно. Учир нь хийсэн өчүүхэн төдий сайн үйл болон муу үйл заавал хэмжигдэх болно. Гэхдээ хийсэн сайн үйл бүхэн арван удаа хийгдсэн мэт, хийсэн бүхий л муу үйл нэг удаа хийгдсэн мэт хүлээн зөвшөөрөгдөх болно.

Сираат: Хүн бүрийн давж өнгөрөх ёстой зам, гүүр юм. Тамын дээгүүр өнгөрөх энэхүү гүүрээр мүминчүүд давж диваажинд хүрч, Аллахтай өөр бусдыг зэрэгцүүлэгсэд, хоёр нүүртэнгүүд болон үл итгэгсэд тэндээс там руу

өнхрөн унах болно. Энэхүү гүүрийг даван туулах хүнд хэцүү, хялбар байх эсэх нь энэ ертөнцөд Аллахад албат байсан хэм хэмжээнээс нь шалтгаалах болно.

Бид бүхэн ибадэтийн төлөө ирж, шүүгдэхийн төлөө буцах болно,

Бид энэ ертөнцөд зочилж, дахин амилахын тулд үхэх болно...

Өгүүллэг: Дахин амилах дөрвөн шувууны түүх

Гэгээн Ибрахим бүгдэд нь: "Миний Эзэн үхүүлж бас амилуулдаг." хэмээн үүндээ өөрөө ч бас чин сэтгэлээсээ итгэдэг байжээ. Гэсэн хэдий ч Гэгээн Ибрахим нэгэн өдөр:

- Аяа Эзэн минь! Үхэгсдийг хэрхэн амилуулахаа надад үзүүлээч! хэмээн Аллахаас гуйжээ. Агуу Аллах түүнд:

- Үхэгсдийг амилуулан гэдэгт маань итгэхгүй байгаа юм уу, Ибрахим? хэмээн асуужээ. Гэгээн Ибрахийм:

- Гарцаагүй итгэж байна, Эзэн минь! Гэхдээ үүнийг нүдээрээ үзээд зүрх сэтгэлээ амраахыг хүссэн юм, хэмээжээ.

Үүний хариуд Агуу Аллах Гэгээн Ибрахимд ийнхүү хэлжээ:

- "Тийм бол дөрвөн шувуу барь! Тэднийг өөртөө сайн гэгч нь дасга! Нэрээр нь дуудахад чам дээр нисэж ирдэг болог. Дараа нь тэднийг ал! Махыг нь хэсэгчлэн хэрчиж, хооронд нь сайн гэгч нь холь! Тэрхүү махаа дөрвөн хэсэгт

хувааж уулын орой дээр хүргэж тавь! Дараа нь шувуудыг дасгасан байдлаараа дууд! Тэд чам дээр нисэж ирэхийг чи харах болно. Үүнийг харсныхаа дараа сайн гэгч нь итгэ, Аллахын хүч чадал агуу билээ. Түүний хийсэн бүхэн дэмий хоосон биш, бүгд утга учиртай хийгддэг.”

Гэгээн Ибрахим, хүсэлт нь биелэсэнд маш их баярлажээ. Тэр даруй тагтаа, тогос, хар хэрээ, азарган тахиа дөрвийг өөртөө дасгаж эхлэв. Хэсэг хугацааны дараа тэрхүү амьтад хаана ч байсан бай Гэгээн Ибрахимийн дууг сонсоод түүний зүг ирдэг болжээ.

Нэгэн өдөр Гэгээн Ибрахим, Аллахын айлдсан байдлаар тэднийг алж махыг нь хооронд нь сайн гэгч нь хольж дөрөв хуваан, дөрвөн уулын оройд аваачин тавьжээ. Дараа нь тэднийг сургасан байдлаараа дуудахад бүгд нэгэн дор амь орж түүний зүг нисэн ирэв.

Үүнийг харсан Гэгээн Ибрахим, сэждэ үйлдэн Рабб Эзэндээ талархаж, Түүнийг гэсэн итгэл үнэмшил нь улам хүчтэй болжээ.

ХУВЬ ТАВИЛАН БОЛОН ОСОЛ АВААРТ ИТГЭХ ИТГЭЛ

Хувь тавилан: Аллах Эзэний, урьдаас; хойчид болох бүхий л зүйлсийн газар болон хугацааг, ямар байдлаар хэзээ болох вэ гэдгийг, -тэд бүтээгдээгүй, ор сураггүй байхад – мэдэж, тэр дагуу болгохыг “Хувь тавилан” гэж байгаа юм. Аллахын Илим буюу бүхнийг мэдэгч шинж чанарын илрэл юм.

Бүх үйлс Аллахын урд өмнө нь бичсэний дагуу болох учиртай. Аль нь ч тохиолдлоор болж байгаа зүйл биш юм.

Осол аваар: Аллахын урд өмнө нь шийдвэрлэсэн зүйлсийн цаг нь болох үед бичигдсэний дагуу бий болохыг хэлж байгаа юм. Шийдвэр гаргагч нь Аллах юм. Энэхүү шийдвэрийн дагуу бүхнийг бий болгож байгаа нь мөн л Аллах Эзэн юм. Тийм учраас хувь тавилан болон осол аваарын хооронд уялдаа холбоо үүсч байгаа юм. Хувь тавилан гэдэг нь төлөвлөгөө, харин осол аваар нь тэрхүү төлөвлөгөөний дагуу хийгдэх ажил, үйл гэж ойлгож болох юм.

Хүмүүсийн хийсэн ажил болон үүнд үүрэх хариуцлагууд:

а) Хүний шийдвэрээс гадуурх зүйлс:

Энэ ертөнцөд мэндлэх, хэзээ нас барах, эрэгтэй эмэгтэй болох... эдгээр зүйлсэд бидний шийдвэр ямар ч нөлөөгүй. Бид энэ бүгдийн төлөө хариуцлага хүлээхгүй.

б) Хүний шийдвэрт хамаатай зүйлс:

Аллах Эзэн бидний шийдвэрт хамаарагдах хувь тавиланг, бидний шийдвэртэй уялдаатай гүйцэлдүүлдэг. Энэ нь Аллах Эзэний бидэнд хариуцлага үүрүүлэхдээ, ямар нэг зүйлийг хүчээр хийлгэчихээд дараа нь “яагаад хийсэн?” гэж шийтгэл өгөх байдалд хүрэхгүйн тулд юм. Тиймээс бидэнд хийсэн зүйлийнхээ хариуцлагыг үүрүүлэхийн тулд хүссэн бүхнээ хийх боломжийг нээлттэй орхисон байдаг. Тухайлбал, жолооч машиныхаа моторын хүчээр баруун зүүн эргүүлж болно, зөв зүйтэй жолоодож

ч болно. Хүссэн үедээ тормозоо дарж зогсож болно. Ямар нэг осол гарах үед жолоочид яагаад машины чинь мотороос их хүч гарч байв гэж асуухгүй. Яагаад хурд хэтрүүлэв, жолоогоо яагаад баруун зүүн эргүүлэв, яагаад зогссонгүй вэ хэмээн асуух болно.

ХАЯИР БОЛОН ШЭРР-Д ИТГЭХ ИТГЭЛ

***Хаяир*: Үр дүн нь хүнд ашигтай зүйлсийг ийнхүү нэрлэнэ.

***Шэрр*: Хүнд хор хөнөөлтэй зүйлсийг ийнхүү нэрлэнэ. Аллахаас өөр бүтээгч байхгүй учраас хаяир болон шэррийг бүтээгч нь мөн Аллах Эзэн юм. Куран Кэримд: “Аллах бол бүхнийг бүтээгч.” хэмээн айлдсан байдаг. Бидний шашинд Хаяир болох зүйлс зарлиг болгож харин Шэрр болох зүйлсийг хориглосон байдаг.

Шэррийг яагаад бүтээх болов? Түүний ач холбогдол:

а) Бидний муу муухай гэж бодох зүйлсэд, бидний үл мэдэх Аллах Эзэний мэдэх ач буян оршиж байдаг. Зарим хүмүүс өөрийнх нь хувьд ашиггүй хор хөнөөлтэй гэж бодсон зүйл нь өөр ихэнх хүмүүст ашигтай байж болох юм.

б) Шэрр нь, хаяирыг ойлгоход тус болдог. Өвчин тусахаас нааш эрүүл саруул байхын үнэ цэнийг бид мэдэхгүй шүү дээ.

Хаяир болон шэррийн өмнөх бидний байдал:

Бид ямар нэг сайн зүйл болоход талархаж. Хүнд хэцүү муу муухай зүйл болоход тэвчиж, даван гарахыг хичээх хэрэгтэй.

Буян хишиг: Бүхий л амьд бие махбодод амьдралын хэрэгцээг хангагч буян хишиг түгээгч нь Аллах Эзэн юм. Гэхдээ буян хишгээ эрж олох нь тухайн хүнд өөрт нь хамааралтай. Хүн өөрт нь ирэх буян хишгийг зөв болон буруу замаар ирж байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.

Үхлийн хугацаа: Үхэл нь хүний амьдрахын төлөө өгсөн цаг хугацаа нь дуусахыг хэлж байгаа юм.

Хэн хэзээ үхэхээ мэдэхгүй. Үхэх хугацаа нь болоход хөгшин, залуу өвчтэй, эрүүл саруул нь хамаагүй бүгд Аллахыг шийдвэрээр үхэх болно. “Тэдний үхэл ирэх үе хором ч оройтохгүй, бас хором ч түрүүлэхгүй.” хэмээх ишлэл нь үхлийн цаг өөрчлөгдөхгүй болохыг бидэнд мэдэгдэж байгаа юм.

МӨРГӨЛИЙН ИШЛЭЛҮҮДИЙГ УНШИХ БАЙДАЛ

Тэмдэглэл: Мөргөлийн ишлэлүүдийг галигаар нь биш, заавал үндсэн арабаар нь цээжлээрэй. Галиг нь, араб үсгүүдийг үнэн зөвөөр нь гаргаж чадахгүй учраас буруу цээжлэх магадлалтай.

Субхаанэкэ

سُبْحَانَكَ اللّٰهُمَّ وَبِحَمْدِكَ وَتَبَارَكَ اسْمُكَ وَتَعَالٰى
جَدُّكَ (وَجَلَّ ثَنَآؤُكَ) وَ لَآ اِلٰهَ غَيْرُكَ.

Сүбхаанэкэ'л-лаахүммэ вэ бихамдик. Вэ тэбаарокэсмүк. Вэ тэаалаа жэддүк. (Вэ жэллэ сэнааүк (*) вэ лаа илаахэ гайрүк.

(*) Энэ хэсэг нь, зөвхөн нас барсан хүнд зориулж уншигдана.

УТГА НЬ: Аяа Аллах минь! Та бүхий л алдаа дутагдлаас ямагт ангид билээ, Танд талархан магтмуй. Таны нэр алдар үлэмж дээд билээ. Мөн таны алдар цуу машид агуу билээ. Танаас өөр, мөргөн залбирах ямар ч бурхан үгүй.

Эттэхияяаату

اَلتَّحِيَّاتُ لِلّٰهِ وَالصَّلَوَاتُ وَالطَّيِّبَاتُ السَّلاَمُ عَلَيْكَ
اَيُّهَا النَّبِىُّ وَرَحْمَةُ اللّٰهِ وَبَرَكَاتُهُ السَّلاَمُ عَلَيْنَاوَعَلٰى
عِبَادِاللّٰهِ الصَّالِحِينَ اَشْهَدُ اَنْ لَآ اِلٰهَ اِلاَّ اللّٰهُ
وَاَشْهَدُ اَنَّ مُحَمَّدًاعَبْدُهُ وَرَسُولُهُ.

Эттэхияяаату лиллаахи вэс-солэвааату вэ'т-тояяибаат. Эссэлааму алэйкэ эюююхэ'н-нэбиюю вэ рахмэ-туллаахи вэ бэро-каатүх. Эссэлааму алэйнаа вэ алаа ибаадил-лаахи'с-соолихийн. Эшхэдү энлаа илаахэ иллаллаах. Вэ эшхэду эннэ Мухаммэдэн абдүхүү вэ Расуулүх.

УТГА НЬ: Хэл, бие мах бодь болон эд баялгаараа үйлдэх зан үйлс бүхэн зөвхөн Аллахын төлөө. Аяа ариун Элчээ! Аллахын хайр ивээл, нигүүлсэл болон элбэг дэлбэг буян хишиг нь чамд оногдог. Энх тайван, эрүүл мэнд бидэнд болон Аллахын үнэнч боолуудад оногдог. Би өөрийн биеэр гэрчлэе Аллахаас өөр бурхан үгүй. Дахин би өөрийн биеэр гэрчлэе Мухаммэд Түүний боол буюу элч юм.

Аллахүммэ Солли

اَللّٰهُمَّ صَلِّ عَلٰى مُحَمَّدٍ وَ عَلٰى اٰلِ مُحَمَّدٍ كَمَا صَلَّيْتَ
عَلٰى اِبْرَاهِيمَ وَ عَلٰى اٰلِ اِبْرَاهِيمَ اِنَّكَ حَمِيدٌ مَجِيدٌ.

Аллахүммэ солли алаа Мухаммэдин вэ алаа аали Мухаммэд. Кэмаа соллэйтэ алаа иброохиймэ вэ алаа аали иброохийм. Иннэкэ хамийдүм-мэжийд.

УТГА НЬ: Аллах минь! Гэгээн Ибрахим болон түүний гэр бүлийг өршөөн нигүүлсэнтэй адилаар бидний гэгээн Мухаммэд болон түүний гэр бүлийг энэрэн нигүүлсэгтүн. Гарцаагүй агуу магтаалын эзэн хийгээд үлэмж дээд нь Та билээ.

Аллахүммэ Баарик

اَللّٰهُمَّ بَارِكْ عَلٰى مُحَمَّدٍ وَ عَلٰى اٰلِ مُحَمَّدٍ كَمَا بَارَكْتَ
عَلٰى اِبْرَاهِيمَ وَ عَلٰى اٰلِ اِبْرَاهِيمَ اِنَّكَ حَمِيدٌ مَجِيدٌ.

Аллахүммэ баарик алаа Мухаммэдин вэ алаа аали Мухаммэд. Кэмаа баароктэ алаа иброохиймэ вэ алаа аали иброохийм. Иннэкэ хамийдүм-мэжийд.

УТГА НЬ: Аллах минь! Гэгээн Ибрахим болон түүний гэр бүлд нь элбэг дэлбэг буян хишиг соёрхсоны адилаар бидний гэгээн Мухаммэд болон түүний гэр бүлд нь элбэг дэлбэг буян хишиг соёрхогтун. Гарцаагүй агуу магтаалын эзэн хийгээд үлэмж дээд нь Та билээ.

Раббэнаа Болон Раббэнагфирли

رَبَّنَآ اٰتِنَا فِي الدُّنْيَا حَسَنَةً وَ فِي الْاٰخِرَةِ حَسَنَةً وَقِنَا عَذَابَ النَّارِ ۞

رَبَّنَا اغْفِرْ لِى وَ لِوَالِدَىَّ وَ لِلْمُؤْمِنِينَ يَوْمَ يَقُومُ الْحِسَابِ ۞

Раббэнаа аатинаа фи'д-дүняаа хасанэтэн вэ фил-аахироти хасанэтэн вэ кынаа азаабэннаар.

Раббэнаг-фирлий вэ ли-ваалидэяяэ вэлил мү'минийнэ яэвмэ яэкуумү'л-хисааб.

УТГА НЬ: Аяа Эзэн минь! Бидэнд энэ хорвоогийн амьдралд болон хойд ертөнцийн амьдралд сайн сайхныг хайрла. Энэрэл нигүүлсээрэй биднийг тамын гэсгээлээс авар. Аяа Эзэн минь! Намайг, Ээжийг минь, Аавыг минь бас бүхий л мү'минчүүдийг агуу шүүлтийн өдөр өршөөж хайрла.

Кунүт Залбирлууд

اَللّٰهُمَّ إِنَّا نَسْتَعِينُكَ وَ نَسْتَغْفِرُكَ وَ نَسْتَهْدِيكَ وَ نُؤْمِنُ بِكَ وَ نَتُوبُ

اِلَيْكَ وَ نَتَوَكَّلُ عَلَيْكَ وَ نُثْنِى عَلَيْكَ الْخَيْرَ كُلَّهُ نَشْكُرُكَ

وَ لاَ نَكْفُرُكَ وَ نَخْلَعُ وَ نَتْرُكُ مَنْ يَفْجُرُكَ.

Аллаахүммэ иннаа нэс'тэ-ийнүкэ вэ нэстагфирукэ вэ нэстэхдийкэ вэ ну'мину бикэ вэ нэтүүбү илэйкэ вэ нэтэвэккэлү алэйкэ вэ нүсний алэйкэ'л-хаяро күллэхү нэшкүрүкэ вэ лаа нэкфүрүк. Вэ нахлагу вэ нэтрүкү мэн яафжүрүк.

Аллах минь! Бид танаас тусламж хүснэм, мөн Танаас өршөөл эрнэм. Бас биднийг зөв шулуун замд чиглүүлэхийг хүснэм. Бид Танд итгэнэ сүсэглэж, бас танаас нүглээ наманчлан. Мөн бүхий л үйл хэргээ танд даатгана найдна. Ийнхүү хамаг сайн сайхан бүхэн танаас ирсэн хэмээн бид магтан дуулна. Бидэнд хайрласан энэхүү буян хишигт чинь талархан, үл тэрсэлмүй. Танд тэрслэн нүүр буруулагчдыг бид орхино.

اَللّٰهُمَّ اِيَّاكَ نَعْبُدُ وَ لَكَ نُصَلِّى وَ نَسْجُدُ وَ اِلَيْكَ نَسعْىٰ وَ نَحفِدُ نَرْجُو
رَحْمَتَكَ وَ نَخْشٰى عَذَابَكَ اِنَّ عَذَابَكَ بِاْلكُفَّارِ مُلْحِقٌ.

Аллаахүммэ ияяаакэ на'буду вэ лэкэ нусолли вэ нэсжүдү вэ илэйкэ нас'аа вэ нахфидү наржүү рахмэтэкэ вэ нахшаа азаабэкэ инна азаабэкэ би'л-күффаари мүл'хик.

УТГА НЬ: Аллах минь! Бид зөвхөн танд сүсэглэж, албат болмуй. Зөвхөн таны төлөө мөргөл үйлдэж, бас зөвхөн таны төлөө сөгдөн залбирч, бас зөвхөн танд хорогдоном. Танд сэтгэлийн гүнээс итгэж, Таны хайр ивээлийг хүснэм. Мөн таны гашуун гэсгээлээс айн гэлмэнэ. Учир нь Таны тамын гэсгээл үл сүсэглэгчдийг бүрхэнэ.

Аяатүл Күрси

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ ۞ اللّٰهُ لاَ إِلَـهَ إِلاَّ هُوَ الْحَيُّ الْقَيُّومُ لاَ
تَأْخُذُهُ سِنَةٌ وَلاَ نَوْمٌ لَّهُ مَا فِي السَّمَاوَاتِ وَمَا فِي الأَرْضِ مَن ذَا الَّذِي

يَشْفَعُ عِنْدَهُ إِلاَّ بِإِذْنِهِ يَعْلَمُ مَا بَيْنَ أَيْدِيهِمْ وَمَا خَلْفَهُمْ وَلاَ يُحِيطُونَ بِشَيْءٍ مِّنْ عِلْمِهِ إِلاَّ بِمَا شَاء وَسِعَ كُرْسِيُّهُ السَّمَاوَاتِ وَالأَرْضَ وَلاَ يَؤُودُهُ حِفْظُهُمَا وَهُوَ الْعَلِيُّ الْعَظِيمُ

Аллаахү лаа илаахэ иллаа хүвэ'л-хаяюү'л-кояюүүм. Лаа тэ'хузүхүү синэтүввэлаа нэуум. Лэхүү маа фи'с-сэмааваати вэ маа фи'л-ардь. Мэн зэ'ллэзий яэшфау ындэхүү иллаа би изних. Яа'лэмү маа бэйнэ эйдиихим вэ маа халфэхүм. Вэлаа юүхийтуунэ бишэй-ин мин илмихии иллаа бимаа шааь. Вэсиа күрсияюүхү'с-сэмааваати вэ'л-ардь. Вэ лаа еэ'-үүдүхүү хыфзухүмаа вэ хүвэ'л-алияюүл-азийм.

УТГА НЬ: Аллах Эзэн машид ангид бөгөөд түүнээс өөр эзэн үгүй. Тэрбээр эхлэл төгсгөлгүй мөнхөд оршино. Мөн Тэрбээр мөнхөд өөрөөрөө оршин тогтногч билээ. Тэрбээр хэзээ ч үл зүүрмэглэнэ мөнхөд сэрүүн оршино. Тэнгэр хийгээд газарт орших буй бүхэн зөвхөн түүнийх бөлгөө. Түүний зөвшөөрөлгүйгээр хэн Түүний нигур дор ивээлд нь багтах билээ дээ?! Тэрбээр сүсэглэгчдийгээ юу хийснийг болон юу хийх гэж буйг мэднэ. (ямар ч зүйл Түүнээс нууц үлдэнэ гэж үгүй) Түүний хүмүүст зааж сургаснаас гадна, тэд Түүний арвин эрдмийн сангаас өчүүхэн хэсгийг ч үл мэдэж чадна. Тэрбээр тэнгэр хийгээд газрыг эзэгнэнхэн оршино. Мөн тэнгэр хийгээд газрыг сахин хамгаалахад түүнд өчүүхэн ч бэрхшээл үл тулгаран. Тэрбээр машид сүр жавхлант хийгээд аугаа хүчирхэг билээ.

Фатиха Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ

اَلْحَمْدُ لِلّٰهِ رَبِّ الْعَالَمِينَ ﴿٢﴾ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ ﴿٣﴾ مَالِكِ يَوْمِ الدِّينِ ﴿٤﴾
إِيَّاكَ نَعْبُدُ وَإِيَّاكَ نَسْتَعِينُ ﴿٥﴾ اِهْدِنَا الصِّرَاطَ الْمُسْتَقِيمَ ﴿٦﴾ صِرَاطَ الَّذِينَ
أَنْعَمْتَ عَلَيْهِمْ غَيْرِ الْمَغْضُوبِ عَلَيْهِمْ وَلَا الضَّالِّينَ ﴿٧﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахиим

Элхамдү лиллаахи Робби'л-аалэмийн. Эр-Рахмаани'р-Рахийм. Маалики еэвмид-дийн. Ияяаакэ на'будү вэ ияяаакэ нэста-ийн. Ихдина'с-сыроото'л-мүстакийм. Сироотол-лэзийнэ эн'амтэ алэйхим, гайри'л-магдууби алэйхим вэ лэ'д-дооллийн.

УТГА НЬ: 1. Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

2. Бүхий л талархал зөвхөн ертөнцийн Эзэн Аллахын төлөө юм.

3. Тэрбээр энэрэлт хийгээд нигүүлсэнгүй билээ.

4. Тэрбээр их шүүлтийн өдрийн Эзэн юм.

5. Бид зөвхөн танд л мөргөн залбирч, зөвхөн танаас л тусламж хүснэ.

6. Биднийг зөв шулуун замаараа хөтөл.

7. Хилэгнүүлэгсэд болон төөрөгсдийн замаар бус, Өөрсдөд нь буян хишиг хайрлагсдын замаар.

Наас Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

قُلْ أَعُوذُ بِرَبِّ النَّاسِ ﴿١﴾ مَلِكِ النَّاسِ﴿٢﴾ إِلَهِ النَّاسِ ﴿٣﴾ مِن شَرِّ الْوَسْوَاسِ الْخَنَّاسِ ﴿٤﴾ الَّذِي يُوَسْوِسُ فِي صُدُورِ النَّاسِ ﴿٥﴾ مِنَ الْجِنَّةِ وَ النَّاسِ ﴿٦﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Кул эуузү биробби'н-наас. Мэлики'н-наас. Илаахи'н-наас. Мин шэррил вэсвааси'л-хоннаас. Эллэзий юүвэсвису фий судүүри'н-наас. Минэ'л-жиннэти вэ'н-наас.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. (Аяа Мухаммэд) Хэлэгтүн; Хорогдоном би, хүмүүний Эзэнтэн болох Аллахад.

2. Хүмүүний Эзэнтэнд.

3. Хүмүүний Аллахад.

4. Тэр зальт хорон муу санаат ховчийн хороос.

5. Тэр нь, хүмүүний зүрх сэтгэлд үргэлж тээнэгэлзлэл төрүүлж муу муухайг шивнэдэг.

6. Жйнн болон хүмүүнээс.(хорон муу санаат ховчийн хороос Аллахад хорогдоном би)

Фэлаак Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

قُلْ أَعُوذُ بِرَبِّ الْفَلَقِ ﴿١﴾ مِن شَرِّ مَا خَلَقَ ﴿٢﴾ وَمِن شَرِّ غَاسِقٍ إِذَا وَقَبَ ﴿٣﴾ وَمِن شَرِّ النَّفَّاثَاتِ فِي الْعُقَدِ ﴿٤﴾ وَمِن شَرِّ حَاسِدٍ إِذَا حَسَدَ ﴿٥﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Кул эуузү би-робби'л фэлак. Мин шэрри маа холак. Вэ мин шэрри гоосыкын изаа вэкоб. Вэ мин шэрриннэффаасаати фи'л-укод. Вэ мин шэрри хаасидин изаа хасэд.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. (Аяа Мухаммэд) Хэлэгтүн; Хорогдоном би, үүрийн Эзэнтэн болох Аллахад.

2. Түүний Бүтээсэн хорон муу зүйлээс нь.

3. Түнэр харанхуй бүрхэхэд гэнэт ирэх тэр шөнийн хорлолоос.

4. Тэр бэрхшээлүүдийг тарнидаж буй тарнидагчдын хар муу үйлээс нь.

5. Мөн атаархал нь буцалж буй атаархагчдын хорлолоос үүрийн Эзэнтэнд хорогдоном би.

Ихлаас Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

قُلْ هُوَ اللَّهُ أَحَدٌ ﴿١﴾ اللَّهُ الصَّمَدُ ﴿٢﴾ لَمْ يَلِدْ وَلَمْ يُولَدْ ﴿٣﴾

وَلَمْ يَكُن لَّهُ كُفُواً أَحَدٌ ﴿٤﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Кул хүваллаахү эхад. Аллаахү'с-сомэд. Лэм яэлид вэ лэм юүүлэд. Вэ лэм яэкүллэхүү күфүвэн эхад.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. (Аяа мухаммэд) Хэлэгтүн; тэрбээр Аллах цор ганц бөлгөө.

2. Аллах төгс төгөлдөр ашид мөнх юм. (бүхий л биеэс түүний эрхшээлд, харин Тэрбээр ямагт эрхшээлээс ангид юм)

3. Тэрбээр төрөөгүй бөгөөд бусдыг төрүүлээгүй.

4. Түүнтэй хэнийг ч жишиж зүйрлэшгүй билээ.

Бүх төрлийн муу муухай үйл хийгээд гай зовлонгоос хамгаалах бүлэгүүд:

"Гэгээн элч (с.а.с) ямар нэгэн зүйлээс болж тавгүйтэх үедээ мөн орой орондоо орохдоо "Ихлаас, Фэлаак, Наас" бүлгүүдийг уншиж гараа үлээн толгой болон нүрнээсээ эхлээд доошоо бүтэн биеэ илдэг байсан бөгөөд үүнийг 3 удаа давтдаг байсан." хэмээн Гэгээн Айшэ дамжуулан хэлсэн байдаг.

Тэббэт Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ

تَبَّتْ يَدَا أَبِي لَهَبٍ وَتَبَّ ﴿١﴾ مَا أَغْنَى عَنْهُ مَالُهُ وَمَا كَسَبَ ﴿٢﴾ سَيَصْلَى نَاراً

ذَاتَ لَهَبٍ ﴿٣﴾ وَامْرَأَتُهُ حَمَّالَةَ الْحَطَبِ ﴿٤﴾ فِي جِيدِهَا حَبْلٌ مِّن مَّسَدٍ ﴿٥﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

*Тэббэт яэдаа эбий лэхэбин вэ тэбб. Маа агнаа анхү маалүхүү вэмаа кэсаб. Сэёослаа наарон заатэ лэхэб. Вэмроэтүх*хаммаалэтэл-хатоб. Фий жийдихаа хаблүм мин мэсэд.*

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлээ.

1. Эбү Лэхэбийн хоёр гар хатаж хорчийг! Угаасаа хатсан болой.

2. Түүний эд хөрөнгө хийгээд олсон бүхэн түүнд ямарч тус болсонгүй.

3. Тэр, дүрэлзсэн догшин галд шатах болно.

4. Түлээ зөөгч хэмээн түүний эхнэр бас (там уруу шидэгдэх болно).

5. Мөн түүний хүзүүнд хурма (хасарваань) модны хулсаар томсон уяа зүүгдэх болно.

Наср Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ

إِذَا جَاء نَصْرُ اللَّهِ وَالْفَتْحُ ﴿١﴾ وَرَأَيْتَ النَّاسَ يَدْخُلُونَ فِي دِينِ اللَّهِ أَفْوَاجاً ﴿٢﴾

فَسَبِّحْ بِحَمْدِ رَبِّكَ وَاسْتَغْفِرْهُ إِنَّهُ كَانَ تَوَّاباً ﴿٣﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Изаа жаа э насру'л-лаахи вэ'л-фэтх. Вэ роэятэ'н-наасэ яэдхулүүнэ фий дийниллаахи эфваажээ. Фэсэббих би-хамдй Роббикэ вэстагфирх, иннэхү каанэ тэвваабаа.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. Аллахын тусламж болон аугаа ялалт ирэх үед.

2. Хүмүүнийг бүлэг бүлгээрээ Аллахын шашинд орж буйг харах үед.

3. Ийнхүү Эзэнтнээ шагшин магтаж, талархан дуулж мөн түүнээс өршөөл эрэгтүн. Эргэлзээгүй тэрбээр аугаа их өршөөгч билээ.

Каафируун Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ

قُلْ يَا أَيُّهَا الْكَافِرُونَ ﴿١﴾ لَا أَعْبُدُ مَا تَعْبُدُونَ ﴿٢﴾ وَلَا أَنتُمْ عَابِدُونَ مَا أَعْبُدُ
﴿٣﴾ وَلَا أَنَا عَابِدٌ مَّا عَبَدتُّمْ ﴿٤﴾ وَلَا أَنتُمْ عَابِدُونَ مَا أَعْبُدُ ﴿٥﴾ لَكُمْ دِينُكُمْ
وَلِيَ دِينِ ﴿٦﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Кул яаа эяюүхэ'л-каафируун. Лаа а'бүдү маа та'бүдүүн. Вэ лаа энтүм аабидүүнэ маа а'бүд. Вэ лаа энаа аабидүм маа абэдтүм. Вэлаа энтүм аабидүүнэ маа а'бүд. Лэкүм дийнүкүм вэли-яэдийн.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. (Мухаммэд) Тэдэнд хэлэгтүн; аяа үл сүсэглэгсэдээ.

2. Би та нарын сүсэглэж буйд үл сүсэглэнэ.

3. Та нар ч гэсэн миний сүсэглэж буйд үл сүсэглэцгээнэ.

4. Би та нарын сүсэглэж буйд сүсэглэгч биш болой.

5. Та нар ч гэсэн миний сүсэглэж буйд сүсэглэх нэгэн биш билээ.

6. Иймээс та нарын шашин та нарынх, миний шашин бол минийх болой.

Кэвсэр Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

إِنَّا أَعْطَيْنَاكَ الْكَوْثَرَ ﴿١﴾ فَصَلِّ لِرَبِّكَ وَانْحَرْ ﴿٢﴾ إِنَّ شَانِئَكَ هُوَ الْأَبْتَرُ ﴿٣﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Иннаа а'тоянаа кэл-кэвсэр. Фэ-солли ли-Роббикэ вэнхар. Иннэ шааниэкэ хүвэл-эбтэр.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. (Аяа Мухаммэд) Гарцаагүй Бид, чамд кэвсэрийг (Аугаа их буян хишиг) өгсөн билээ.

2. Иймээс чи Эзэнийхээ төлөө мөргөл үйлд бас курбан өргө.

3. Үнэндээ чамайг үзэн ядагчдын өөрсдийнхөн үр удам тасарсан болой.

Маа'уун Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

أَرَأَيْتَ الَّذِي يُكَذِّبُ بِالدِّينِ ﴿١﴾ فَذَلِكَ الَّذِي يَدُعُّ الْيَتِيمَ ﴿٢﴾ وَلَا يَحُضُّ
عَلَى طَعَامِ الْمِسْكِينِ ﴿٣﴾ فَوَيْلٌ لِّلْمُصَلِّينَ ﴿٤﴾ الَّذِينَ هُمْ عَن صَلَاتِهِمْ
سَاهُونَ ﴿٥﴾ الَّذِينَ هُمْ يُرَاؤُونَ ﴿٦﴾ وَيَمْنَعُونَ الْمَاعُونَ ﴿٧﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Эроэйтэ'л-лэзий юукэззибу бид-дийн. Фэзааликэл-лэзий яэдү'үл-яэтийм. Вэлаа яэхудду алаа тоаами'л-мискийн. Фэвэйлүллил-мусоллийн. Эллэзийнэхүм ан

солаатихим саахүүн. Эллэзийнэхүм юүрооүүн. Вэ яэм нэ-үүнэл маа'уун.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. Чи харсан уу тэр шашиныг худал хуурмаг хэмээгсдийг?
2. Өнчин өрөөснийг нударч түлхэгсэд эд нар шүү дээ!
3. Ядуу зүдүүг хооллож тусламж үл үзүүлнэ.
4. Даан ч дээ шившигийн юм тэр мөргөл үйлдэгсэд,
5. Тэд мөргөл үйлдэхдээ хайнга ханддаг юм.
6. Тэд зүгээр л дүр үзүүлэгсэд шүү дээ.
7. Мөн тэд өглөгөөс зайлсхийдэг (зэкат өгдөггүй).

Кураиш Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيمِ

لِإِيلَافِ قُرَيْشٍ ﴿١﴾ إِيلَافِهِمْ رِحْلَةَ الشِّتَاءِ وَالصَّيْفِ ﴿٢﴾ فَلْيَعْبُدُوا رَبَّ هَٰذَا الْبَيْتِ ﴿٣﴾ الَّذِي أَطْعَمَهُم مِّن جُوعٍ وَآمَنَهُم مِّنْ خَوْفٍ ﴿٤﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Ли-ийлаафи кураиш. Ийлаафихим рихлэтэ'ш-шитаа-и ва'с-сояф. Фэляа'бүдүү робба хаазэ'л-бэят. Эллэзий эт'амахүм мин жуу'ин вэ аамэнэхүм мин хаууф.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. Курайшд боломж олгосны учир,
2. Өвөл болон зун аян замд явах боломж олгосны учир,

3. Тэр бүхний төлөө Ка'бэгийн Эзэнд сүсэглэн залбирцгаагтун!

4. Ийнхүү Тэрбээр тэднийг өлсөж цангахаас аварч бас айх аюулаас нь хамгаалсан билээ.

Фийл Бүлэг

بِسْمِ اللّٰهِ الرَّحْمٰنِ الرَّحِيم

أَلَمْ تَرَ كَيْفَ فَعَلَ رَبُّكَ بِأَصْحَابِ الْفِيلِ ﴿١﴾ أَلَمْ يَجْعَلْ كَيْدَهُمْ فِي تَضْلِيلٍ
﴿٢﴾ وَأَرْسَلَ عَلَيْهِمْ طَيْرًا أَبَابِيلَ ﴿٣﴾ تَرْمِيهِم بِحِجَارَةٍ مِّن سِجِّيلٍ ﴿٤﴾
فَجَعَلَهُمْ كَعَصْفٍ مَّأْكُولٍ ﴿٥﴾

Бисмиллаахир-Рахмаанир-Рахийм

Элэм тэро кэйфэ фэ'алэ Роббүкэ би-асхааби'л-фийл. Элэм яэж'ал кэйдэ-хүм фий тадлийл. Вэ эрсэлэ алэйхим тоярон эбаабийл. Тэрмийхим би-хижааротим мин сижжийл. Фэжэ-алэхүм кэ'асфим мэ'күүл.

УТГА НЬ: Энэрэлт нигүүлсэнгүй Аллахын алдраар эхлэе.

1. Аллах Эзэн зааны эздийг яасныг чи хараагүй гэж үү дээ!

2. Тэдний урихыг талаар болгоогүй гэж үү?

3. Тэдэн рүү сүрэг сүрэг шувуудыг илгээн.

4. Тэдэн дээр шавраар шатаасан хатуу чулуунууд унагаав.

5. Ийнхүү тэднийг сийчүүлсэн тариан талбай мэт бут ниргэсэн болой.

ГАРЧИГ

Асуулт Хариулт Бүхий Шашины Анхны Мэдэгдэхүүнүүд 5

32 Фарз 8

Бие Засах Газрын Ариун Цэвэр 12

Абдэст Угаалга 12

Тэеэммүм 21

Гусул Угаалга 24

Азан/Мөргөлийн Дуудлага 29

Мөргөл 32

Кэлимэ-И Тэвхид 60

Аллахад Итгэх Итгэл 62

Мэлэк Буюу Сахиусан Тэнгэрүүдэд итгэх итгэл .. 69

Судруудад Итгэх Итгэл 71

Гэгээн Элч Нарт Итгэх Итгэл 72

Ертөнцийн Төгсгөлийн Өдөрт Итгэх Итгэл 74

Хувь Тавилан Болон Осол Аваарт Итгэх Итгэл 78

Хаяир Болон Шэрр-Д Итгэх Итгэл 80

Мөргөлийн Ишлэлүүдийг Унших Байдал 81